



ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ, САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ

*Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан жижиг,
дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдлын талаарх
түүвэр судалгааны үр дүнг нэгтгэн тайлагнасан тул
Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.*

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХ ТҮҮВЭР
СУДАЛГАА 2014 ОН

Оршил	i
Бүлэг 1. Судалгааны зорилго, аргачлал, түүвэрлэлт	5
Бүлэг 2. Ерөнхий мэдээлэл	6
2.1. Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр.....	7
2.2. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны төрөл	7
2.3. Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа.....	7
2.4. Ажиллагсдын тоо.....	7
2.5. Борлуулалтын орлого	8
Бүлэг 3. Макро эдийн засаг, нийгэм, хууль эрх зүйн орчин.....	9
3.1. Макро эдийн засгийн орчин	10
3.2. Нийгмийн орчин	13
3.3. Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин	15
Бүлэг 4. Зах зээлийн орчин.....	18
4.1. Дэд бүтцийн байдал.....	19
4.2. Зах зээлийн орчин.....	21
4.3. Зардлын байдал.....	24
Бүлэг 5. ЖДҮ-ийн санхүүжилтийн байдал	27
5.1. Санхүүжилтийн эх үүсвэр	28
5.2. Зээлийн нөхцөл	31
5.3. Бусад	31
Дүгнэлт	34

Хавсралт	Судалгааны үр дүн (нийслэл хот, аймгуудаар)	36
1.1.	Улаанбаатар хот	
1.2.	Архангай аймаг	
1.3.	Баянхонгор аймаг	
1.4.	Баян-Өлгий аймаг	
1.5.	Булган аймаг	
1.6.	Говь-Алтай аймаг	
1.7.	Говь-Сүмбэр аймаг	
1.8.	Дархан-Уул аймаг	
1.9.	Дорнод аймаг	
1.10.	Дорноговь аймаг	
1.11.	Дундговь аймаг	
1.12.	Завхан аймаг	
1.13.	Орхон аймаг	
1.14.	Өвөрхангай аймаг	
1.15.	Өмнөговь аймаг	
1.16.	Сүхбаатар аймаг	
1.17.	Сэлэнгэ аймаг	
1.18.	Төв аймаг	
1.19.	Увс аймаг	
1.20.	Ховд аймаг	
1.21.	Хөвсгөл аймаг	
1.22.	Хэнтий аймаг	

Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулж, орлогын тэгш бус хуваарилалтыг багасган нийгмийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлж, хувийн секторын хөгжлийг хангахад онцгой хувь нэмрийг үзүүлдэг байна. Дэлхийн олон орны жишээнээс ЖДҮ-үүд эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байгааг харж болно. АХБ-наас 2013 онд гаргасан Азийн орнуудын ЖДҮ-ийн санхүүжилт, хяналтын тайлангаас харахад 2007-2012 оны дундаж үзүүлэлтээр нийт аж ахуйн нэгжийн 98 хувь нь ЖДҮ, тэдгээрт ажиллагсад нийт ажиллах хүчний 66 хувь, тэдгээрийн үйлдвэрлэл ДНБ-ий 38 хувь, тэдгээрийн экспорт нийт экспортын 30 хувийг тус тус бүрдүүлсэн байна. Улс орнуудын ЖДҮ-ийн гадаад худалдаанд үзүүлэх нөлөө нэмэгдсээр байна. Тухайлбал, манай улсын хөрш БНХАУ-ын хувьд 2012 оны байдлаар нийт экспортын 41.5 хувь (өмнөх оноосоо 6.8 нэгж хувиар нэмэгдсэн), Тайланд улсын нийт экспортын 28.8 хувь (3.7 нэгж хувиар нэмэгдсэн) нь ЖДҮ эрхлэгчдэд ногджээ. Манай орны нийт аж ахуйн нэгжийн дийлэнхийг ЖДҮ-үүд бүрдүүлж байгаа ба эдгээрийг хөгжүүлэх нь эдийн засгийн хөгжилд олон талын ач холбогдолтой.

Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар “МЭЖ” ХХК-тай хамтран Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-ийн өнөөгийн хөгжил, тулгарч буй саад бэрхшээл болон санхүүжилтийн нөхцөл байдлыг тогтоох зорилготой түүвэр судалгааг 2011, 2012 онд орон даяар явуулсан. Энэхүү 3 дахь удаагийн түүвэр судалгааг 2014 оны 6 дугаар сард явууллаа. Уг судалгаанд “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлд заасны дагуу ЖДҮ эрхлэгчдийг ангилж, түүвэрчлэн хамруулсан бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн салбар, газар зүйн байршил, ажилчдын тоо зэргийг харгалзан үзэж санамсаргүй түүврийн аргаар судалгааны нэгжийг сонгон авлаа.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ эрхлэгчдэд макро эдийн засгийн орчин, нийгмийн орчин, хууль, эрх зүйн орчин, дэд бүтэц, зах зээлийн байдал болон зардлын талаас ЖДҮ эрхлэхэд ямар хүчин зүйлс хамгийн их бэрхшээл болж байгааг тогтоох, төрөөс баримталж буй бодлого хэр хүртээмжтэй байгааг тандах, ЖДҮ-ийн санхүүжилтийн байдал, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход оршино. ЖДҮ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд ямар төрлийн хүндрэл, бэрхшээл хамгийн ихээр тулгарч байгааг улсын хэмжээнд, нийслэл хот болон аймаг, үйл ажиллагаа эрхэлж буй эдийн засгийн салбаруудаар нь тогтоож, өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулж, түүнд нөлөөлж буй шалтгаануудыг илрүүлэхийг зорилоо.

ЖДҮ эрхлэгчдийн дунд явуулсан энэхүү судалгаанд хүн амын тал хувь нь оршин суудаг, ААН-ийн дийлэнх хувь нь үйл ажиллагаа явуулдаг Улаанбаатар хотоос 1002, аймгуудын хувьд үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдийн тоог харгалзан Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Баян-Өлгий, Ховд, Завхан, Өмнөговь аймгаас тус бүр 50 орчим, бусад аймгуудаас тус бүр 30-40 орчим түүврийг сонгож, эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 1940 ЖДҮ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг хамрууллаа. Судалгааны мэдээллийг түүвэрлэлтэнд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдээс санал асуулга бөглүүлэх, ярилцлага авах хэлбэрээр бүрдүүлсэн. Өмнөх судалгааны адил ЖДҮ эрхлэгч хувиараа хөдөлмөр эрхлэгч болон аж ахуйн нэгжийн удирдлагын

түвшнээс (эзэн, гүйцэтгэх захирал, ерөнхий менежер, нягтлан бодогч зэрэг гүйцэтгэх удирдлага) судалгааг авсан.

“Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийн 5 дугаар бүлгийн 15.1.4-т жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн талаар дэмжих, тэдгээрийн өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах талаар тусгажээ. Уг судалгааны ажлаар ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн өнөөгийн байдал, зээл авахад болон төлөхөд үүсч буй хүндрэл, цаашдын шаардлагатай санхүүжилтийн хүү, хэмжээ болон хугацааг тогтоох зорилт тавин ажиллалаа.

Судалгааны ажил нь үндсэн таван бүлгээс бүрдэх бөгөөд нэгдүгээр бүлэгт судалгааны ажлын зорилго, аргачлал болон түүвэрлэлтийн талаар дэлгэрэнгүй тусгасан. Хоёрдугаар бүлэг буюу Ерөнхий мэдээлэл бүлэгт түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийг хэлбэр, үйл ажиллагааны төрөл, үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа (*насжилт*), ажиллагсдын тоо, жилийн борлуулалтын орлогын байдлаар нь ангилж судаллаа. Гуравдугаар бүлэг буюу макро эдийн засаг, нийгэм, хууль, эрх зүйн орчин ЖДҮ-ийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг харууллаа. Дөрөвдүгээр бүлэг буюу Зах зээлийн орчин бүлэгт дэд бүтэц, зах зээл, зардлын байдал зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг судалж, хамгийн их саад бэрхшээл болж байгаа хүчин зүйлсийг тодорхойлохыг зорилоо. Тавдугаар бүлэг бүлэг буюу ЖДҮ-ийн санхүүжилтийн байдал бүлэгт ЖДҮ эрхлэгчдийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ, хөнгөлөлттэй зээлийн олдоц, зээлийн нөхцөл зэргийн талаар авч үзлээ. Судалгааны дүнг нийслэл хот, аймаг тус бүрээр нь гаргаж хавсралтанд тусгав.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГАЧЛАЛ, ТҮҮВЭРЛЭЛТ

1.1. Зорилго

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, санхүүжилт, тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлж, бодлогын шийдвэр гаргалтанд ашиглах, үнэн зөв мэдээллээр хангахад оршино.

Санал асуулга авах зорилгот бүлэг нь ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгжийн эзэн/гүйцэтгэх удирдлага (захирал, гүйцэтгэх, ерөнхий менежер, нягтлан гэх мэт) ба хувиараа хөдөлмөр эрхлэгч нар байв.

1.2. Аргачлал

Судалгааны мэдээллийн санг санал асуулга явуулах замаар цуглуулсан бөгөөд судалгаанд хамрагдсан ЖДҮ-ийн эзэн, гүйцэтгэх удирдлага, холбогдох албан тушаалтнаас¹ ярилцлагын аргаар мэдээлэл авсан болно.

Судалгааны санал асуулгыг бусад орнуудын хийсэн ижил төстэй судалгааны санал асуулгууд дээр үндэслэн боловсруулав.

1.3. Түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийн нэгжийг сонгохдоо ААН-үүдийн байршил, ажиллагсдын тоо болон үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үзэж, эх олонлогийг төлөөлөхүйц түүврийг санамсаргүйгээр сонголоо. Оновчтой түүврийн хэмжээг тодорхойлохдоо түүврийн харьцаа ба дунжийн хувьд 95%-ийн итгэх интервалд (хамгийн багадаа 5%-ийн ач холбогдлын түвшинд) статистикийн хувьд найдвартай байх, хамгийн бага хангалттай хэмжээний түүврийг үүсгэхээр сонголоо².

Түүврийн эх олонлогт 2012 оны эцсийн байдлаар Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны Бизнес регистрийн санд³ бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 51,940 аж ахуйн нэгжүүдийг хамрууллаа.

Статистик тооцооллоос оновчтой түүврийн хэмжээг Улаанбаатар хотоос 1000, аймгуудаас 30-50 буюу нийт 1850 байхаар төлөвлөв. Санал асуулгын хариулалтын чанараас хамааран зарим газраас илүү

¹ ААН-ийн үйл ажиллагаа, санхүүжилтийн талаар мэдээлэл өгөх бүрэн боломжтой удирдах албан тушаалтнууд.

² $n = \frac{z^2 s^2 N}{\Delta^2 N + z^2 s^2}$; n-хамгийн бага түүврийн хэмжээ, z- итгэх интервалд харгалзах критек утга (95%-ийн итгэх түвшинд 1.96-тай тэнцүү байна), s- стандарт хазайлт, N- эх олонлогийн хэмжээ Δ- үнэлгээний нарийвчлал.

³ ҮСХ, Жилийн тайлан, 2012 он.

эсвэл дутуу тооны санал асуулга авах магадлалтай байсан бөгөөд нийт дүнгээр төлөвлөсөн хэмжээнээс 4.8%-иар илүү буюу 1,940 түүвэр санамсаргүйгээр сонгов.

Санал асуулгад оролцогчдыг аймаг, нийслэлээр авч үзвэл нийт оролцогчдын 51.5%-ийг Улаанбаатар хотын, 48.5%-ийг орон нутгийн ЖДҮ эрхлэгчид эзэлж байгаа /Хүснэгт 1.1/.

Харин идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийт 51,940 ААН-үүдийн 3.7% нь судалгаанд хамрагдсан бөгөөд Улаанбаатар хотын 3.0%, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудад 3.0-5.7%, Говьсүмбэр аймгийн 11.1%, бусад аймгуудад 1.5-3.0% нь хамрагдсан байна.

Хүснэгт 1.1 Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн тоо

Аймаг, нийслэлээр	Үйл ажиллагаа явуулж буй ААН		Судалгаанд хамрагдсан ААН			
	Тоо	Хувийн жин	Төлөвлөсөн	Авсан	Хувийн жин	Нийт ААН-д эзлэх хувь
Баян-Өлгий	1,000	1.9%	50	57	2.9%	5.7%
Говь-Алтай	616	1.2%	30	30	1.5%	4.9%
Завхан	938	1.8%	50	51	2.6%	5.4%
Увс	983	1.9%	50	50	2.6%	5.1%
Ховд	1,326	2.6%	50	58	3.0%	4.4%
Архангай	696	1.3%	40	40	2.1%	5.7%
Баянхонгор	554	1.1%	30	34	1.8%	6.1%
Булган	762	1.5%	40	45	2.3%	5.9%
Орхон	1,585	3.1%	50	53	2.7%	3.3%
Өвөрхангай	792	1.5%	40	43	2.2%	5.4%
Хөвсгөл	819	1.6%	40	40	2.1%	4.9%
Говьсүмбэр	180	0.3%	20	20	1.0%	11.1%
Дархан	1,699	3.3%	50	59	3.0%	3.5%
Дорноговь	607	1.2%	30	30	1.5%	4.9%
Дундговь	493	0.9%	30	30	1.5%	6.1%
Өмнөговь	903	1.7%	50	50	2.6%	5.5%
Сэлэнгэ	1,775	3.4%	50	50	2.6%	2.8%
Төв	1,036	2.0%	50	100	5.2%	9.7%
Дорнод	848	1.6%	40	40	2.1%	4.7%
Сүхбаатар	522	1.0%	30	30	1.5%	5.7%
Хэнтий	663	1.3%	30	30	1.5%	4.5%
Улаанбаатар	33,143	63.8%	1,000	1,000	51.5%	3.0%
Нийт	51,940	100.0%	1,850	1,940	100.0%	3.7%

Эх үүсвэр: ҮСХ, Монголбанк ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААН-үүдийн 90% нь 1-9 ажиллагсадтай, 4.7% нь 10-19 ажиллагсадтай, 3.3% нь 20-49 ажиллагсадтай, 2.1% нь 50-иас дээш тооны ажиллагсадтай байна /Хүснэгт 1.2/.

Хүснэгт 1.2 Бүртгэлтэй ААН-ийн тоо, ажиллагсдын тооны бүлгээр

Ажиллагсдын тооны бүлэг	ААН-ийн тоо	Хувийн жин
1-9	81,384	89.9%
10-19	4,215	4.7%
20-49	3,015	3.3%
50-аас дээш	1,926	2.1%
Нийт	90,540	100.0%

Эх үүсвэр: ҮСХ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



Аж ахуйн нэгжийн хамрагдсан байдал: Санал асуулгад нийт 1,940 ЖДҮ эрхлэгчид хамрагдсан бөгөөд үүний 51.5% нь Улаанбаатар хотоос, 48.5% нь орон нутгаас оролцов.

Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр: Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх хувийг худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй дотоодын хөрөнгө оруулалттай ХХК-иуд эзэлж байна.

Аж ахуйн нэгжүүдийн төрөл: Судалгаанд оролцогчдын ихэнх нь 1-5 жил үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд 1-9 хүртэлх тооны ажиллагсадтай, жилийн 50 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой байна.

БҮЛГИЙН АГУУЛГА:

- Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны төрөл
- Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа
- Ажиллагсдын тоо
- Борлуулалтын орлого

Ерөнхий мэдээлэл


Энэхүү бүлэгт санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн талаарх ерөнхий мэдээллийг харуулав.

2.1. Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг өмчлөлийн хэлбэрээр нь авч үзвэл дийлэнх хэсэг нь буюу 94% нь дотоодын хөрөнгө оруулалттай ААН-үүд байна. Гадаадын хөрөнгө оруулалттай 2%, холимог өмчлөлтэй ЖДҮ эрхлэгчид 4%-ийг эзэлж байна.

Зураг 2.1 ААН-ийн өмчлөлийн хэлбэр

(ЖДҮ-ийн харуулсан хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)


Улаанбаатар хот болон аймгуудын хувьд гадаадын хөрөнгө оруулалттай болон холимог өмчлөлтэй ААН-үүдийн нийлбэр дүн 8%-иас хэтрэхгүй байна⁴.

2.2. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны төрөл

Санал асуулгад оролцогчид голчлон худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 2.2 ААН-ийн үйл ажиллагааны төрөл

(ЖДҮ-ийн харуулсан хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)


Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны төрлийн хувийн жинг аймгуудаар харвал худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ эрхлэгч Улаанбаатар хот, Дундговь болон Сүхбаатар аймгуудаас, үйлдвэрлэлийн

⁴ Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ эрхлэгч Өмнөговь, Баянхонгор аймгуудаас, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ эрхлэгч Говьсүмбэр, Хөвсгөл, Завхан, Төв аймгуудаас бусдаасаа түлхүү оролцжээ.

Зураг 2.3 ААН-ийн үйл ажиллагааны төрөл, аймаг

(ЖДҮ-ийн харуулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

2.3. Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа

ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа явуулж буй хугацаагаар нь авч үзвэл 13% нь 1 жил хүртэлх, 40% нь 1-5 жил, 24% нь 5-10 жил, 24% нь 10-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2.4 ААН-ийн үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа

(ЖДҮ-ийн харуулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

2.4. Ажиллагсдын тоо

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь буюу 67% нь 1-9 хүртэлх тооны ажиллагсадтай байна. Дөрөвний нэг хэсэг нь 10-49 хүртэлх тооны ажиллагсадтай бол 50-аас дээш тооны ажиллагсадтай ЖДҮ эрхлэгчид нийт оролцогчдын 6%-ийг эзэлж байна.

Зураг 2.5 ААН-ийн ажиллагсдын тоо

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

2.5. Борлуулалтын орлого

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 65% нь жилд 50 сая хүртэлх төгрөгний борлуулалтын орлоготой байна. Үүнээс 10 сая хүртэл болон 10-50 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой ЖДҮ эрхлэгч бараг ижил хувьтай байна.

Зураг 2.6 Жилийн борлуулалтын орлого

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)


50-100 сая болон 100-500 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ЖДҮ эрхлэгч нийт оролцогсдын 28%-ийг эзэлж байгаа бол 500 сая төгрөгөөс дээш орлоготой нь 6%-ийг эзэлж байна.

Улаанбаатар хот, Ховд, Өвөрхангай, Төв аймгуудад 50 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой ЖДҮ эрхлэгчид хамгийн их байна. Харин 50-100 сая төгрөгийн орлоготой нь Дорнод, Хөвсгөл аймгуудад хамгийн их байгаа бол 100 саяас дээш төгрөгийн орлоготой нь Завхан, Дархан-Уул аймгуудад бусдаас илүү хувьтай байна.

Зураг 2.7 Жилийн борлуулалтын орлого, аймгуудаар

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)

■ 10 сая ₮ хүртэл
■ 10-50 сая ₮ хүртэл
■ 50-100 сая ₮ хүртэл
■ 100-500 сая ₮ хүртэл
■ 500 сая - 1 тэрбум ₮



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

МАКРО ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Макро эдийн засгийн орчин: Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь өмнөх судалгаанд оролцогчидтой адил ЖДҮ эрхлэх эдийн засгийн таатай орчин хангалттай бүрдээгүй гэж үзжээ.

Санал асуулгад оролцогчид инфляцийн түвшин нам дор, тогтвортой бөгөөд ханш тогтвортой байх нь өөрсдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ гэж үзсэн нь өмнөх судалгааны үр дүнтэй адил байна. Эдийн засаг 2013 оны эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж байгаа боловч ЖДҮ эрхлэгчид энэхүү өсөлтийн үр шим хангалттай хүртэхгүй байна гэжээ.

Нийгмийн орчин: Судалгааны үр дүнгээр ядуурал, ажилгүйдлийн түвшин ЖДҮ-ийн хөгжилд нийгмийн зүгээс учруулах хамгийн гол бэрхшээл хэвээр байгаа боловч өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад үнэлгээ нь их хүндрэлтэйгээс бага хүндрэлтэй гэсэн үнэлгээнд шилжих хандлагатай байна.

Хууль эрх зүйн орчин: Судалгааны үр дүнгээс харахад ЖДҮ эрхлэгчдэд ЗГ болон ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олдоц хомс, төрийн байгууллагын үйлчилгээ чирэгдэлтэй, зээлийн хүү өндөр, зам тээврийн хөгжил хангалттай бус, хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох боломж муу зэрэг нь их хүндрэл учруулдаг байна. Энэ нь мөн л өмнөх судалгааны үр дүнтэй нийцтэй байна.

БҮЛГИЙН АГУУЛГА:


- Макро эдийн засгийн орчин
- Нийгмийн орчин
- Хууль эрх зүйн орчин

3.1 Макро эдийн засгийн орчин

Дэлхийн санхүүгийн хямралаас үүдэн манай улсын эдийн засгийн өсөлт 2009 онд 1.3%-иар буурсан ч уул уурхайн салбарт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом нэмэгдэж, улмаар эрдэс бүтээгдэхүүний экспорт тэр дундаа нүүрсний экспорт огцом нэмэгдсэнээр 2011 онд эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоонд хүрч, 17.5 хувьтай гарсан.

Харин 2012 оноос Монгол улсад орж ирэх гадаад валютын урсгал болон гадаад цэвэр активын хэмжээ буурах хандлагатай болж эдийн засгийн бодит өсөлт саарсанч Засгийн газар, Монголбанкны зүгээс эдийн засгийг бүхэлд нь тогтворжуулах, учирч болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлэх бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг үргэлжлүүлэн хангасны зэрэгцээ эдийн засгийн тэнцвэртэй өсөлтөд дэмжлэг үзүүлэв. Ингэснээр Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2013 онд 11.7%-тай гарч, 3 дахь жилдээ дараалан 2 оронтой тоонд хадгалагджээ. Дотоодын нийт бүтээгдэхүүний 2013 оны бодит өсөлтийг эдийн засгийн салбараар задалж үзвэл уул уурхайн олборлолт 3.2%, бөөний болон жижиглэнгийн худалдаа 2.1%, хөдөө аж ахуй 2.0%, барилга 1.4%, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.3%, бусад салбар 2.8%-ийг тус тус бүрдүүлж байна.

Зураг 3.1 Эдийн засгийн өсөлт, салбараар




Эх үүсвэр: УСХороо

Дэлхий санхүү эдийн засгийн 2008-2009 оны хямралын улмаас манай улсын эдийн засаг зогсонги байдалд орж Олон улсын валютын сантай хамтран тусгай хөтөлбөр хэрэгжүүлсэнээр инфляци буурч 2009 онд дефляцитай гарсан бол 2010-2012 оны хооронд төсвийн тэлэх бодлого болон нийлүүлэлтийн талын зарим хүчин зүйлээс шалтгаалан инфляци эргээд өсч 15-20 хувьд хүрч байв. 2012 оны сүүлээр Монголбанк Засгийн газартай хамтран Үнийг тогтворжуулах хөтөлбөр

хэрэгжүүлж эхэлснээр 2013 оны эхний хагаст инфляци буурч нэгт оронтой тоонд хүрсэн боловч хоёрдугаар хагаст төгрөгийн ханш суларч, дотоодын хэрэглээний барааны үнэд үзүүлэх дарамт ихсэх хандлагатай болж инфляци 12.3 хувьтай гарсан.

Нүүрсний экспортын биет хэмжээ 2013 он гарсаар буурахын зэрэгцээ, дэлхийн зах зээлийн үнэ унаснаар экспортын орлого огцом багасч, урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэв. Урсгал тэнцлийн алдагдлыг санхүүжүүлж ирсэн голлох эх үүсвэр болох гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан, төсвөөс гадуурх зарцуулалтууд хийгдсэн, улирлын шинжтэй гадаад валютын эрэлт өсч байсан зэрэг нь 2014 оны эхний хагаст төгрөгийн ам.доллартай харьцах ханш жилийн 27 хувиар сулрахад нөлөөлөв.

Зураг 3.2 Ханш ба инфляци



Эх үүсвэр: УСХороо, Монголбанк

Монголбанк санхүүгийн салбар, эдийн засгийг болзошгүй хямралаас сэргийлэх, эдийн засгийг бүхэлд нь тогтворжуулах, бодит секторын идэвхжилийг дэмжих зорилтын хүрээнд цогц арга хэмжээг 2013 онд хэрэгжүүлсэн:

- Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг арилгах зорилготой тусгайлан хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж эхлэв. Энэхүү дунд хугацааны хөтөлбөр нь гол нэрийн бараа, бүтээгдэхүүн болох шатахуун, мах, гурил, зарим нэр төрлийн барилгын материалын жижиглэнгийн үнийг тогтворжуулах, зах зээлийн зарчимд суурилсан агуулахын санхүүжилтийн механизмыг шинээр бий болгоход чиглэгдэж байна.
- Монголбанкнаас эдийн засгийн бодит секторт бүтээмж бий болгох мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллав. Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, зээлийн тасалдал үүсэхээс сэргийлэх, эдийн засгийн идэвхжил, бодит секторыг

дэмжихийн тулд Монголбанк бодлогын хүүг нийт 2.75 нэгж хувиар бууруулахын зэрэгцээ 900 тэрбум төгрөг буюу M2 мөнгөний 15 хувьтай тэнцэх хэмжээний хадгаламжийг банкуудад байршуулсан.

- Монголбанк хөдөө аж ахуй, орон сууцны барилга зэрэг эдийн засгийн тодорхой салбаруудыг дэмжих замаар эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх, ажлын байрыг хамгаалах, орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлэх замаар дундаж давхаргын хуримтлалыг тууштай нэмэгдүүлэх, дотоодын зээл, хуримтлал, хөрөнгө оруулалтыг сайжруулахад анхаарч ажиллав.

2013 оны эцсийн байдлаар хөтөлбөрийн зээл 1,922 тэрбумын үлдэгдэлтэй байна. Нийт хөтөлбөрийн зээлийн 48 хувийг ипотека, 32 хувийг барилга, 9 хувийг шатахуун, 7 хувийг хүнс, 3 хувийг түлш нүүрс, 1 хувийг импортын барааны (цемент, арматурын улирлын шинжтэй нийлүүлэлтийн тасалдлыг бууруулах) зээл тус тус эзэлж байна.




Өнгөрсөн онд эдийн засгийн өсөлт 11.7 хувь байсан боловч ЖДҮ эрхлэгчдийн талаас дээш хувь нь эдийн засгийн өндөр өсөлт ЖДҮ эрхлэгчдэд нөлөөлөөгүй гэж үзсэн байна.



Харин валютын ханшийн уналт болон инфляци нь ЖДҮ эрхлэгчдийн 70 орчим хувьд муугаар нөлөөлж байна гэж хариулсан нь ханш болон инфляцийн индекс сөрөг утгатай гарахад нөлөөлжээ.

Аймаг, нийслэлээр

Макро эдийн засгийн байдлын индексийг аймгуудаар харьцуулбал Ховд, Булган, Архангай аймгуудад хамгийн хүндээр тус байгаа бол Баян-Өлгий, Дорнод, Завхан, Баянхонгор, Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймгууд дахь ЖДҮ эрхлэгчид төдийлөн хүндрэлтэй биш гэж хариулжээ.



Эдийн засгийн өсөлтөөр Говь-Алтай, Говьсүмбэр гэсэн хоёр аймаг эерэг үзүүлэлттэй байна. Харин хамгийн муу үзүүлэлттэй нь Булган, Хэнтий, Сэлэнгэ, Төв аймгууд байна. Инфляцийн хувьд ганц Говьсүмбэр аймгуудын хувьд эерэг бусад аймгуудынх муу гэсэн үнэлгээтэй байна. Ханшийн хувьд бүх аймгуудын хувьд ойролцоогоор -1 буюу муу гэж хариулжээ /Хүснэгт 3.1/.

Хүснэгт 3.1 Макро эдийн засгийн байдал, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийц, 1= сайн, 2=маш сайн/

	Эдийн засгийн өсөлт	Инфляци	Ханш
Улсын дүн	-0.49	-0.85	-0.87
Архангай	-0.45	-1.43	-1.35
Баян-Өлгий	-0.44	-0.75	-0.95
Булган	-0.88	-1.10	-1.35
Баянхонгор	-0.30	-0.79	-0.88
Дархан-Уул	-0.11	-0.91	-0.80
Дорнод	-0.03	-0.97	-1.12
Дорноговь	-0.30	-0.76	-0.55
Дундговь	-0.60	-1.00	-1.00
Говь-Алтай	0.17	-1.20	-1.30
Говьсүмбэр	0.30	0.05	-0.20
Хэнтий	-0.83	-1.03	-1.12
Ховд	-0.67	-1.30	-1.37
Хөвсгөл	-0.61	-1.08	-1.13
Орхон	-0.63	-1.06	-1.13
Сэлэнгэ	-0.81	-0.96	-1.10
Сүхбаатар	-0.47	-1.20	-1.03
Төв	-0.83	-0.98	-1.00
Улаанбаатар	-0.53	-0.70	-0.70
Өмнөговь	0.36	-1.08	-1.06
Увс	-0.57	-0.93	-1.10
Өвөрхангай	-0.56	-1.21	-1.21
Завхан	-0.18	-0.94	-0.88

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Дүгнэлт

Макро эдийн засгийн байдал бизнэс эрхлэгчдийн хувьд таатай орчин болж чадаагүй байна. Эдийн засгийн өсөлт хэдийгээр 2 оронтой тоогоор илэрхийлэгдэж байгаа боловч уул уурхайгаас олсон орлого нь ЖДҮ эрхлэгчидэд хангалттай дэмжлэг болж чадахгүй байна. Өнгөрсөн онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш жилийн 20 гаруй хувиар унаж инфляци 12 хувьд хүрсэнтэй харьцуулахад санал асуулгад оролцогчид инфляци болон ханшийн уналт бизнест нь муугаар нөлөөлсөн гэж хариулсан нь бодит байдлаас нэг их зөрөөгүй байна. Макро эдийн засгийн байдлын үзүүлэлтүүдийг аймаг нийслэлээр авч үзвэл эдийн засгийн өсөлтийн хувьд бага зэрэг ялгаатай боловч инфляци болон ханшийн хувьд бараг ялгаагүй болно.

3.2 Нийгмийн орчин

Монгол улсын ДНБ-ий жилийн өсөлт 2013 онд 11.7%, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 3,971⁵ ам доллар болж өмнөх оноос 9.3%-иар өссөн бөгөөд ядуурлын түвшин 27.4% (2012), ажилгүйдлийн түвшин 7.9% болж тус тус буурсан байна. Хүний хөгжлийн индекс 0.675 байгаа нь дэлхийн 187 орноос 108-рт жагсаж байгаа бол авилгалын индекс⁶ 0.65 байгаа нь 215 орноос 153-рт жагсаж байна.


Нэгдсэн дүн

ЖДҮ-ийн бизнес эрхлэхэд нийгмийн орчны зүгээс саад болж буй хүчин зүйлсийг хүндрэлтэй /0/-ээс их хүндрэлтэй /-2/ гэсэн чанарын асуултаар асууж, нэгдсэн үнэлгээг тоон утга руу шилжүүлэн тооцлоо.

Нийгмийн орчны хүчин зүйлсийг ядуурал, ажилгүйдэл, хээл хахууль, гэмт хэрэг гэсэн дөрвөн үзүүлэлтээр тооцож ерөнхий индексийг гаргав. Түүвэр судалгааны үр дүнгээр нийгмийн орчны ерөнхий индекс (-1.02) буюу бага хүндрэлтэй гэж дүгнэгдсэн нь өмнөх судалгаануудын дүнтэй харьцуулахад сайжирсан байна.

Зураг 3.6 Нийгмийн орчин

/-2=Их хүндрэлтэй -1= Хүндрэлтэй, 0= Хүндрэлгүй/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Санал асуулгын дүнгээс харахад ЖДҮ эрхлэгчдэд нийгмийн орчны зүгээс ядуурлын түвшин хамгийн их хүндрэл учруулдаг гэж судалгаанд оролцогчид хариулсан байна /Зураг 3.7/.

Үндэсний Статистикийн хорооны “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны дүнгээр 2012 онд ядуурлын түвшин (ядуурлын хамралтын хүрээ) 27.4 болж өмнөх оноос 2.4 нэгж хувиар буурсан хэдий ч ЖДҮ-ийн хөгжилд сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг хэвээр байна.


⁵ ОУВС

⁶ Дэлхийн банк

ЖДҮ эрхлэхэд ажилгүйдэл нийгмийн зүгээс ядуурлын дараа орох гол бэрхшээл гэж дүгнэсэн байна. Үндэсний Статистикийн хорооны “Ажиллах хүчний судалгаа”-ны дүнгээр 2013 онд эдийн засгийн идэвхтэй хүн 1198.3 мянга байгаагаас 1103.6 мянга буюу 92.1% нь ажиллагсад 7.9% нь ажилгүй иргэд байна.

Зураг 3.7 Нийгмийн орчин, үзүүлэлтээр

/-2=Их хүндрэлтэй -1= Хүндрэлтэй, 0= Хүндрэлгүй/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Ажилгүйдэл, ядуурлын түвшин өндөр буюу иргэдийн худалдан авах чадвар сул байх нь эрэлтэд нөлөөлөх замаар бизнес эрхлэхэд голлох бэрхшээл болж байна.

Хээл хахууль болон гэмт хэргийн байдлыг ЖДҮ эрхлэхэд харьцангуй бага хүндрэлтэй гэж үзэж байна. Олон улсын “Трансперэнси Интернэшнл” байгууллагын 2013 онд явуулсан судалгаагаар Монгол улсын авилгын индекс 0.65 гарсан нь хоёр жилийн өмнөхтэй харьцуулахад 0.02 нэгжээр авилгын түвшин буурсан байна.

Шигтгээ 3.1. Ядуурлын индекс

	2010	2011	2012
Ядуурал хамралтын хүрээ	38.7	33.7	27.4
Хот	33.1	28.6	23.2
Хөдөө	49	43.4	35.5
Ядуурлын гүнзгийрэлт	11.5	9.2	7.1
Хот	9.4	7.7	6.2
Хөдөө	15.2	11.8	8.8
Ядуурлын мэдрэмж	4.7	3.5	2.7
Хот	3.7	3	2.4
Хөдөө	6.4	4.5	3.2

Үндэсний статистикийн хорооноос гаргасан тооцоогоор 2012 онд ядуурлын индексүүд харьцангуй эерэг үзүүлэлттэй гарсан байна. Ядуурлын хамралтын хүрээ буюу нийт хүн амд ядуу иргэдийн эзлэх хувь улсын хэмжээнд өмнөх оныхоос 6.3 нэгжээр буурсан бөгөөд Улаанбаатар хотын хувьд 5.9, хөдөө орон нутагт 7.9 нэгжээр буурчээ.

Үүний зэрэгцээ улсын дунджаар ядуурлын гүнзгийрэл буюу ядуурлын шугам 2.1 нэгжээр, ядуурлын мэдрэмж буюу ядуу иргэдийн хоорондох тэгш бус байдал 0.8 нэгжээр тус тус өмнөх оныхоос багассан байна.

Хулгай, дээрэм, залилан болон бие мах бодод гэмтэл учруулах төрлийн гэмт хэрэг нийгэмд түгээмэл байсаар байгаа нь ЖДҮ эрхлэхэд саад учруулж буй бас нэгэн бэрхшээл болж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2013 онд 25.4 мянга болж, өмнөх оноос 14.8 %-иар өссөн байна.

Аймаг, нийслэлээр

Нийгмийн орчны ерөнхий индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Орхон, Сэлэнгэ, Баянхонгор, Булган аймгуудын ЖДҮ эрхлэгчид нийгмийн орчин бизнесийн үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулж байна гэсэн хариултыг илүү өгсөн байна.

Хүснэгт 3.2 Нийгмийн орчин, үзүүлэлтээр

/-2=Их хүндрэлтэй -1=Хүндрэлтэй, 0=Хүндрэлтгүй/

	Ядуурал	Ажилгүйдэл	Хээл хахууль	Гэмт хэрэг
Улсын дүн	-1.21	-1.13	-0.96	-0.77
Архангай	-1.43	-1.40	-0.80	-0.63
Баян-Өлгий	-1.20	-1.14	-1.02	-0.77
Булган	-1.27	-1.20	-1.11	-1.00
Баянхонгор	-1.38	-1.15	-1.15	-0.91
Дархан-Уул	-1.14	-1.21	-1.04	-0.75
Дорнод	-1.18	-1.22	-1.11	-0.52
Дорноговь	-1.03	-0.97	-0.83	-0.72
Дундговь	-1.20	-1.07	-0.85	-0.69
Говь-Алтай	-1.40	-1.37	-0.80	-0.47
Говьсүмбэр	-0.55	-0.60	-0.35	-0.30
Хэнтий	-1.24	-1.21	-1.00	-0.85
Ховд	-1.19	-1.18	-1.08	-0.62
Хөвсгөл	-1.45	-1.55	-0.93	-0.42
Орхон	-1.36	-1.32	-1.48	-1.08
Сэлэнгэ	-1.35	-1.31	-1.20	-0.95
Сүхбаатар	-1.13	-1.10	-0.87	-0.70
Төв	-1.29	-1.35	-0.90	-0.64
Улаанбаатар	-1.19	-1.06	-0.95	-0.84
Өмнөговь	-1.08	-1.02	-0.70	-0.30
Увс	-1.26	-1.20	-1.10	-0.81
Өвөрхангай	-1.23	-1.19	-1.02	-0.83
Завхан	-1.18	-1.16	-0.77	-0.40

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Харин Говьсүмбэр, Өмнөговь, Завхан аймгуудын ЖДҮ эрхлэгчид нийгмийн орчинг бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй бага хүндрэлтэй гэж үзжээ.


Ядуурал, ажилгүйдэл Хөвсгөл, Архангай, Говь-Алтай аймгуудын бизнес эрхлэгчдэд илүү хүндрэл учруулж байгаа бол Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь аймгуудад харьцангуй бага хүндрэлтэй байна.

Нийгмийн орчинд хамгийн муу үнэлгээг Орхон, Сэлэнгэ, Баянхонгор, Булган аймгуудын судалгааны оролцсон ЖДҮ эрхлэгчид өгсөн бөгөөд ядуурал, ажилгүйдлээс гадна хээл хахууль бизнесийн үйл ажиллагаанд нь нэлээд хүндрэл учруулдаг байна. Мөн гэмт хэргийн байдлыг бусад аймгуудын үнэлгээнээс илүү муугаар дүгнэсэн байлаа. Бусад аймгуудын хувьд ихэнх нь гэмт хэргийн байдлыг

хүндрэлгүйгээс бага хүндрэлтэй (-0.3-0.8 орчим) гэсэн үнэлгээг өгсөн байна.

Зураг 3.8 Нийгмийн орчин, аймгуудаар

/-2=Их хүндрэлтэй -1=Хүндрэлтэй, 0=Хүндрэлтгүй/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Дүгнэлт

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид нийгмийн орчинг ерөнхийдөө бага хүндрэлтэй гэж дүгнэсэн нь өмнөх судалгаануудын дүнгтэй харьцуулахад сайжирсан байна. Санал асуулгын үр дүнгээс харахад ЖДҮ-ийн хөгжилд нийгмийн зүгээс учруулах хамгийн гол бэрхшээл нь ядуурал, ажилгүйдэл болж байна. Харин хээл хахууль болон гэмт бизнес эрхлэхэд харьцангуй бага хүндрэл учруулж байна.

Ядуурал, ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь нэг талаас хэрэглэгчдийн худалдан авах чадвар сул байгааг харуулах бөгөөд үүнээс шалтгаалж ЖДҮ эрхлэгчдийн борлуулалт хангалттай түвшинд хийгдэхгүйд хүрч, урт хугацаанд эргэлтийн хөрөнгөөр дутагдах, хэрэв зээлтэй бол зээлийн эргэн төлөлтийн дарамтанд орох зэрэг санхүүгийн хүндрэлүүдтэй тулгарах магадлалтай. Нөгөө талаас ядуурал, ажилгүйдэл нийгэмд өндөр байгаагаас ЖДҮ эрхлэгчдийн тодорхой хэсэг нь санхүүжилт авах барьцаа хөрөнгө, баталгаа байхгүй байгааг нотолж байна.

3.3 Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин

ЖДУ-ийн эрх зүйн орчинг сайжруулан, ЖДУ-ийг хөгжүүлснээр өрсөлдөх чадвар бүхий ЖДУ-үүд бий болж, ажлын байр нэмэгдэн, ажилгүйдэл, ядуурал буурч, дотоодын үйлдвэрлэл өсөх зэрэг чухал үр нөлөөтэй. Иймээс улс орнууд ЖДУ эрхлэгчдэд хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд анхаарч, бодлогын арга хэмжээг авсаар байна. Манай орны хувьд УИХ 2007 онд “Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль”-ийг баталсан нь ЖДУ-ийн тодорхойлолт, ЖДУ-ийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхой болгож, улмаар төрөөс жижиг, дунд үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжилд ЖДУ-ийн үзүүлэх хувь нэмэр, ач холбогдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн ЖДУ эрхлэгчдэд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээс буюу “Лизинг”-ээр авах боломжийг бий болгож “Санхүүгийн түрээс /Лизинг/-ийн тухай хууль”-ийг 2006 онд батлуулж хэрэгжүүлж байгаа нь барьцаа хөрөнгийн боломж тааруу бизнес эрхлэгчдэд худалдан авч байгаа тоног төхөөрөмжөө барьцаалан зээл авч үйл ажиллагаагаа явуулах боломж бүрдсэн. “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-д /2007 онд/ ЖДУ-ийг хөгжүүлэх санг оруулан хуульчилж өгснөөр ЖДУ шинээр бий болох, өргөжин хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлсэн. Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийг 2009 онд УИХ-аар батлуулан мөрдөн ажиллаж байна. Уг хуульд парк байгуулах зорилгод ЖДУ, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох гэж тусгаж өгсөн.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг 2009 оны 7 дугаар сард баталж, 2009 оноос хойш хэрэгжүүлж байгаа бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацааг сунгасан. Тус хуулийн дагуу “Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалт”-ыг Засгийн газраас шинэчлэн батлан гаргаж байсан. Хамгийн сүүлд 2014 оны 6 сард Засгийн газрын тогтоолоор 594 төрлийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх жагсаалтыг гаргасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 онд батлагдсан бөгөөд уг хуулинд малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг арга зүй, зөвлөгөө, сургалт, санхүүгийн талаар дэмжих талаар тусгагдсан.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль 2012 онд батлагдсан. Улмаар банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах болсон.


Түүнчлэн орон нутгийн удирдлага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага зэргээс ЖДУ эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр, төслүүд хэрэгжсээр байна. Энэ мэтчилэн хууль, эрх зүйн хүрээнд ЖДУ эрхлэгчдийг дэмжиж буй ажлууд хийгдэж байгаа ч тэдгээрийг хамрах байдал хангалттай бус байгааг судалгаанд хамрагдагсад хэлж байлаа.

Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр хууль эрх зүй, зохицуулалтын орчны ерөнхий индекс хангалттай сайн биш **(-0.41)** гэж дүгнэгдсэн боловч өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бага зэрэг сайжирсан байна. /Зураг 4.13/.

Зураг 3.9 Хууль, эрх зүйн орчин

/-2= маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДУ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Хууль эрх зүй, зохицуулалтын орчныг дотор нь задлан авч үзвэл гадаад худалдаа хийх нөхцөл, төрийн байгууллагын үйлчилгээ, татварын тогтолцоог, хууль, эрх зүйн орчныг хамгийн хүндрэл учруулж байна гэж дүгнэсэн байна.

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид гадаад худалдаа хийх нөхцөлд хамгийн муу үнэлгээг өгснөөс гадна хээл хахууль бизнесийн үйл ажиллагаанд нь их хүндрэл учруулдаг, нөгөө талаас төрийн байгууллагын үйл ажиллагаа нь тууштай, ил тод байж чадахгүй, хүнд сурталтай байдаг зэргээс төрийн байгууллагын үйлчилгээнд доогуур үнэлгээг өгөхөд хүргэжээ.

Зураг 3.10 Хууль эрх зүйн орчин, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

“Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль”, “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”, “Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль” зэрэг ЖДҮ эрхлэгчтэй холбоотой нэлээд хууль батлагдсанаасаа хойш багагүй хугацаа өнгөрч байгаа боловч судалгаанд оролцож буй жижиг бизнес эрхлэгчид эдгээрийн талаар мэдэхгүй, хэрхэн хөнгөлөлт эдлэхээ мэдэхгүй байгаа нь хууль эрх зүйн орчинд өгсөн үнэлгээ муу гарахад нөлөөлжээ.

2013 оны эцсийн байдлаар Монгол улсад 99,603 ААН бүртгэгдсэнээс 54,929 ААН үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн дийлэнх буюу 98% хуулийн тодорхойлолтоор жижиг дунд үйлдвэрт хамаарах ААН-үүд байна. Үйл ажиллагаа тогтмол явуулж буй ААН-ийн дийлэнх хэсгийг ЖДҮ эрхлэгчид эзэлж байгаа хэдий ч ЖДҮ эрхлэгчдийн нэлээд хувь татвараа тогтмол төлдөггүй, санхүүгийн хүнд байдалтай байсаар байна. Энэ нь татварын тогтолцоо гуравдагч гол хүндрэл болоход нөлөөлсөн гэж үзэж байна.

Газар эзэмших харилцаанд өгсөн үнэлгээ өмнөх судалгаанаас бага зэрэг сайжирсан нь судалгаанд оролцогсад өөрсдийн гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн зориулалтаар тодорхой хэмжээний газрын хувьчилж авч байгаатай холбоотой юм. Даатгалын тогтолцоог ерөнхийдөө боломжийн гэж дүгнэсэн байна.


Аймаг, нийслэлээр

Хууль эрх зүй, зохицуулалтын орчны ерөнхий индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Орхон, Хөвсгөл, Булган, Ховд, Говь-Алтай, Сэлэнгэ аймгийн санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид улсын дундажтай харьцуулахад ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих эрх зүй, хяналт шалгалт болон татварын бодлогын таатай орчин хангалттай сайн биш байна гэж дүгнэжээ. Харин Говьсүмбэр, Төв, Дундговь, Хэнтий аймгуудад бусад аймгуудтай

харьцуулахад хууль эрх зүйн тогтолцоо, төрийн үйлчилгээ нь харьцангуй боломжийн байгаа гэсэн үнэлгээг өглөө /Зураг 4.14/.

Зураг 3.11 Хууль эрх зүйн орчин, аймгуудаар

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Хууль эрх зүй, зохицуулалтын орчинг тодорхойлогч үзүүлэлтүүдээр авч үзвэл Орхон, Ховд, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад **хууль эрх зүйн орчинг** төдийлөн хангалттай сайн биш байна гэж үзсэн бол Говьсүмбэр, Баян-Өлгий, Дорнод аймгуудад харьцангуй боломжийн байгаа гэсэн үнэлгээг өглөө. /Хүснэгт 4.6/.

Орхон, Хөвсгөл, Архангай, Ховд, Өмнөговь, Сүхбаатар аймагт **төрийн байгууллагын үйлчилгээ, татварын тогтолцоо** муу гэж үзсэн бол Говьсүмбэр, Төв аймагт ЖДҮ эрхлэгчид хангалттай сайн биш, мөн бусад аймгууд ч хангалтгүй гэж үзжээ.

Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь, Завхан аймагт бизнес эрхлэгчид **гадаад худалдаа хийх нөхцөл** муу байна гэж үзсэн байна. Харин хилийн боомт бүхий Дорнод, Сүхбаатар, Баян-Өлгий, Дорноговь аймагт үйл ажиллагаа эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад харьцангуй боломжийн гэж дүгнэжээ.

Даатгалын үйлчилгээнд Говь-Алтай, Сэлэнгэ, Булган, Баянхонгор аймгаас бусад аймгууд боломжийн үнэлгээг түлхүү өгсөн байна.

Улаанбаатар хотод ЖДҮ-ийн үйл ажиллагаа эрхлэгчид хууль, эрх зүйн орчин, гадаад худалдаа хийх нөхцөл, төрийн байгууллагын үйлчилгээнд хамгийн тааруу үнэлгээг бол даатгалын үйлчилгээг боломжийн гэж үзсэн байна.

Хүснэгт 3.3 Хууль эрх зүйн орчин, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн/

	Хууль, эрх зүйн орчин	Татвар (хураамж)-ын тогтолцоо	Гадаад худалдаа хийх нөхцөл	Төрийн байгууллагын үйлчилгээ	Хяналт шалгалтын тогтолцоо	Газар эзэмших харилцаа	Даатгалын үйлчилгээ
Улсын дүн	-0.49	-0.49	-0.54	-0.52	-0.35	-0.36	-0.12
Говьсүмбэр	-0.25	-0.05	-0.45	-0.35	-0.05	-0.05	-0.20
Баян-Өлгий	-0.32	-0.54	-0.30	-0.58	-0.44	-0.46	-0.12
Дорнод	-0.32	-0.39	-0.16	-0.66	-0.32	-0.44	-0.06
Өмнөговь	-0.36	-0.88	-0.86	-0.46	-0.26	-0.08	-0.04
Хэнтий	-0.41	-0.59	-0.46	-0.38	-0.15	-0.41	0.21
Төв	-0.41	-0.35	-0.68	-0.34	-0.07	0.07	0.19
Баянхонгор	-0.41	-0.35	-0.97	-0.55	-0.59	-0.47	-0.48
Өвөрхангай	-0.41	-0.55	-0.71	-0.71	-0.50	-0.46	-0.27
Увс	-0.46	-0.50	-0.59	-0.33	-0.29	-0.45	-0.23
Говь-Алтай	-0.47	-0.67	-0.87	-0.57	-0.53	-0.73	-0.53
Улаанбаатар	-0.49	-0.39	-0.47	-0.46	-0.30	-0.33	-0.10
Завхан	-0.50	-0.51	-0.81	-0.56	-0.23	-0.32	-0.02
Дорноговь	-0.52	-0.60	-0.33	-0.47	-0.47	-0.30	0.00
Булган	-0.52	-0.59	-0.75	-0.75	-0.57	-0.73	-0.49
Архангай	-0.53	-0.80	-0.75	-0.80	-0.70	-0.23	0.00
Дундговь	-0.53	-0.47	-0.63	-0.38	-0.03	-0.14	0.21
Дархан-Уул	-0.58	-0.47	-0.36	-0.60	-0.35	-0.41	0.03
Сүхбаатар	-0.60	-0.87	-0.27	-0.52	-0.77	-0.40	-0.20
Хөвсгөл	-0.62	-0.95	-0.97	-0.79	-0.67	-0.50	-0.29
Сэлэнгэ	-0.64	-0.70	-0.73	-0.69	-0.50	-0.46	-0.49
Ховд	-0.67	-0.74	-0.63	-0.77	-0.37	-0.96	-0.25
Орхон	-0.79	-1.06	-0.73	-1.04	-0.81	-0.62	-0.23

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Хууль, эрх зүйн орчинд өгсөн үнэлгээг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад Улаанбаатар хот болон аймгуудын үнэлгээ аль аль нь бага зэрэг сайжирсан байна. /Хүснэгт 4.7/

Хүснэгт 3.4 Хууль эрх зүйн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн 2=маш сайн/

	2011	2012	2014
Улс	-0.51	-0.50	-0.41
Улаанбаатар	-0.55	-0.45	-0.36
Аймгуудын дундаж	-0.46	-0.54	-0.47

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Дүгнэлт

Хууль, эрх зүйн орчинд өгсөн үнэлгээ өмнөх судалгаануудын дүнгээс ялимгүй сайжирсан бөгөөд боломжийн, муу гэж (-0.41) дүгнэгдсэн байна.

Гадаад худалдаа хийх нөхцөлд энэ удаагийн судалгаагаар хамгийн муу үнэлгээг өгчээ. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн өгсөн тайлбараас үзэхэд гаалийн болон бусад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах боломж, тэдгээрт хамрагдах тоног, төхөөрөмж, бараа бүтээгдэхүүний нэр төрөл цөөн зэргээс гадна ханшийн хэлбэлзэл нь гадаад худалдаа хийхэд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл болж байна.

Хэдийгээр төрийн байгууллагын үйлчилгээ хууль зүйн орчны үзүүлэлтүүдээс тааруу үзүүлэлттэй тооцогдож байгаа ч өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад харьцангуй сайжирчээ. Энэ нь төрийн үйлчилгээний цахим ТҮЦ машиныг Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд байршуулсан нь аж ахуй эрхлэгч байгууллага, иргэдэд төрийн зарим үйлчилгээг түргэн шуурхай авах болсон, төрийн байгууллагад гаргасан гомдол саналаа хэрхэн шийдвэрлэж, ямар шатанд явж байгаа талаар онлайн-аар мэдэх болсон зэрэгтэй холбоотой юм.

Газар эзэмших харилцаанд өгсөн үнэлгээ өмнөх судалгаанаас сайжирсан нь судалгаанд оролцогсод өөрсдийн гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн зориулалтаар тодорхой хэмжээний газрын хувьчилж авч байгаатай холбоотой юм.

ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИН

Дэд бүтэц: Дэд бүтцийн байдалд өгсөн үнэлгээ өмнөх судалгааны дүнгээс сайжирч боломжийн гэж дүгнэгджээ. Энэ нь зарим аймгуудыг 2013 онд хатуу хучилттай замын сүлжээнд холбосон, дулаан усан хангамж сайжирсан, нийт аймаг сумыг хамарсан мэдээлэл холбооны хөгжил манай оронд харьцангуй сайн байдаг зэрэгтэй холбоотой.

Зах зээлийн орчин: Судалгааны үр дүнгээс харахад хэрэглэгчдийн худалдан авах чадвар муу байгаа нь ЖДҮ эрхлэгчдэд сөргөөр нөлөөлж байна. Мөн зах зээлийн багтаамж төдийлөн хангалттай бус байгааг судалгаанд оролцогчид онцолсон байна. Харин технологийн дэвшил, мэдээллийн хүртээмж, зах зээлийн өрсөлдөөнд боломжийн үнэлгээг түлхүү өгсний зэрэгцээ өмнөх судалгааны дүнгээс сайжирсан байлаа.

Зардлын байдал: ЖДҮ эрхлэгчдэд зээлийн хүүний зардал, түүхий эд, түрээс, шимтгэл хураамжийн зардал өмнөх судалгааны адилаар хамгийн их хүндрэл үзүүлсэн хэвээр байна.



БҮЛГИЙН АГУУЛГА:

- Дэд бүтэц
- Зах зээлийн орчин
- Зардлын байдал

4.1 Дэд бүтцийн байдал

2013 оны байдлаар манай улс нийт 6,738 км урт сайжруулсан авто замтай бөгөөд үүнээс хатуу хучилттай 3015.6 км, 2116 км нь сайжруулсан хайрган хучилттай замтай. Монгол улсын хүн амын дийлэнх нь нийслэл хотод төвлөрсөн тул хатуу хучилттай авто замын сүлжээгээр нийт хүн амын 60% нь идэвхтэй зорчдог. 2013 оны эцсийн байдлаар Говь-Алтай, Завхан, Сүхбаатар, Ховд, Увс, Баян-Өлгий гэсэн 6 аймаг хатуу хучилттай замын нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байна. 2016 он гэхэд эдгээр аймгуудыг холбох төлөвлөгөөтэй байна.

Дэлхийн Эдийн Засгийн Форумгаас эрхлэн гаргасан 2013 оны Өрсөлдөх чадварын судалгаанд дэд бүтцийн хөгжлөөрөө 139 орноос 112-т жагссан бол, авто замын чанарын үзүүлэлтээр Монгол улс нийт 139 орноос 2.3 гэсэн оноотой 137-р байрт буюу хөгжлийн түвшин доогуур Непал, Бангладеш, Зимбабве зэрэг орнуудаас ч доогуур жагсаж байна.


Сүүлийн жилүүдэд үүрэн утасны хэрэглэгчдийн тоо мэдэгдэхүйц нэмэгдэж, давхардсан тоогоор 2013 онд 4.2 саяд хүрсэн нь өмнөх оныхоос 24.6 хувиар өсчээ. Харин суурин холбооны хэрэглэгчдийн тоо 2013 онд 210.4 мянга болж, 2012 оныхоос 38.5 хувиар өссөн байна.

Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдлыг бусад орчны ерөнхий индексүүдтэй харьцуулахад хамгийн боломжийн (0.00) гэсэн үнэлгээг өглөө. /

Зураг 4.1 Дэд бүтцийн байдал, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Дэд бүтцийн байдлын ерөнхий индексийг тодорхойлогч үзүүлэлтүүдээр нь задлан авч үзвэл Зам тээврийн хөгжил болон дулаан усан хангамжийн байдал бусад үзүүлэлттэй харьцуулахад сайн биш гэж дүгнэгдлээ. Харин цахилгаан хангамжийг боломжийн, мэдээлэл холбооны салбарыг бараг сайн гэж дүгнэсэн үр дүн гарлаа /Зураг 4.1/.

Өмнөх жилүүдийн индекстэй харьцуулахад зам тээвэр болон дулаан усан хангамж сайжирснаар дэд бүтцийн байдал боломжийн гэсэн үнэлгээтэй гарсан /Зураг 4.2/.

Зураг 4.2 Дэд бүтцийн байдал

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн


Аймаг, нийслэлээр

Дэд бүтцийн байдлын ерөнхий индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Ховд, Завхан, Дорнод болон Увс зэрэг төвөөс алслагдсан аймгуудын санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдал сайн бүрдээгүй гэж үзлээ.

Харин Говьсүмбэр, Өмнөговь, Дорноговь, Дундговь зэрэг аймагт ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдлыг сайн гэж үзсэн нь эдгээр аймгуудын дийлэнх⁷ нь хатуу хучилттай замын нэгдсэн сүлжээнд холбогдсон, цахилгаан дулааны нэгдсэн сүлжээтэй зэрэг нь индекс зэрэг гарахад нөлөөлжээ /Зураг 4.3/.

Зураг 4.3 Дэд бүтцийн байдал, аймгуудаар

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

⁷ Дорноговь аймгаас бусад нь

Дэд бүтцийн байдлыг тодорхойлогч үзүүлэлтүүдийг аймаг, нийслэл хотын хэмжээнд задлан авч үзвэл Завхан, Ховд, Говь-Алтай, Дорнод, Хөвсгөл болон Баян-Өлгий аймгуудад бизнес эрхлэгчид өөрийн аймгийн **зам тээврийн хөгжлийг** бусад аймагтай харьцуулахад сайн биш гэж дүгнэсэн нь эдгээр аймгууд хатуу хучилттай замын нэгдсэн сүлжээнд холбогдоогүй, төвөөс алслагдсан байдал зэрэг нь нөлөөлсөн байж болзошгүй юм. Харин Говьсүмбэр, Дундговь, Дорноговь болон Өмнөговь аймууд зам тээврийн хөгжлөө сайн гэж үнэлжээ.

Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Өвөрхангай, Увс, Сүхбаатар, Дорнод болон Булган аймагт үйл ажиллагаа эрхлэгчид **дулаан хангамжийн** асуудал бусад аймагтай харьцуулахад сайн биш гэсэн үнэлгээг өгсөн бол Төв, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Дархан-Уул болон Говьсүмбэр аймгууд хэвийн гэж үнэллээ.

хучилттай замын бат бөх чанар зэргээс шалтгаалж уг үнэлгээг өгсөн байх талтай. Харин бусад үзүүлэлтийн хувьд нийслэл хотын бизнес эрхлэгчид харьцангуй боломжийн гэсэн үнэлгээг өглөө /Хүснэгт 4.10/.

Дүгнэлт

ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдлыг бусад нөлөөлөгч хүзчин зүйлсийн ерөнхий индексүүдтэй харьцуулахад хамгийн боломжийн **(0.00)** гэсэн үнэлгээг өглөө. Энэ нь 2013 онд Баянхонгор, Дундговь, Дорноговь аймгуудыг хатуу хучилттай замын сүлжээнд холбосон, түүнчлэн дулаан усан хангамж сайжирсантай холбоотой. Харин цахилгаан хангамж болон мэдээлэл холбооны дэд бүтэц өнгөрсөн судалгаатай харьцуулахад бараг өөрчлөгдөөгүй байна. Аймаг нийслэлээр дэд бүтцийн үзүүлэлтүүдийг задалж үзвэл нэлээд ялгаатай байна.

Хүснэгт 4.1 Дэд бүтцийн байдал, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/

	Зам тээвэр	Дулаан усан хангамж	Цахилгаан хангамж	Мэдээлэл холбоо
Улсын дүн	-0.26	-0.13	0.10	0.28
Архангай	-0.43	-0.23	-0.08	0.20
Баян-Өлгий	-0.65	-0.33	0.11	0.40
Булган	-0.23	-0.41	0.11	0.32
Баянхонгор	-0.24	-0.27	0.12	0.27
Дархан-Уул	-0.34	0.09	0.29	0.45
Дорнод	-1.05	-0.29	-0.11	0.44
Дорноговь	0.17	0.13	0.27	0.40
Дундговь	0.50	0.03	0.57	0.67
Говь-Алтай	-0.53	-0.47	0.03	0.57
Говьсүмбэр	0.25	0.15	0.25	0.05
Хэнтий	-0.19	-0.25	-0.07	0.25
Ховд	-0.68	-0.61	-0.27	0.14
Хөвсгөл	-0.30	-0.33	0.26	0.38
Орхон	-0.51	-0.17	-0.06	0.06
Сэлэнгэ	-0.22	-0.30	-0.04	0.04
Сүхбаатар	-0.17	-0.70	-0.23	0.33
Төв	-0.05	0.05	0.30	0.33
Улаанбаатар	-0.20	-0.02	0.14	0.25
Өмнөговь	0.10	0.06	0.12	0.56
Увс	-0.41	-0.52	-0.02	0.15
Өвөрхангай	-0.29	-0.48	-0.28	0.07
Завхан	-0.94	-0.49	-0.29	0.33

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Завхан, Ховд, Сүхбаатар болон Өвөрхангай аймагт үйл ажиллагаа эрхлэгчид **цахилгаан хангамжийн** асуудлыг бусад аймагтай харьцуулахад муу гэж дүгнэсэн бол бусад аймгууд харьцангуй хэвийн гэсэн үнэлгээг өгчээ.

Улаанбаатар хотод ЖДҮ эрхлэгчид зам тээврийн хөгжил сайн биш гэж үнэлсэн нь замын түгжрэл, хатуу

4.2 Зах зээлийн орчин

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид зах зээлийн орчныг **(-0.11)** буюу боломжийн гэж дүгнэсэн нь 2011-2012 онуудын судалгаатай харьцуулахад сайжирсан үр дүнтэй байна.


Зах зээлийн орчныг илэрхийлэх хүчин зүйлсээс **хэрэглэгчдийн худалдан авах чадвар (-0.39)** хамгийн муу үнэлгээтэй гарлаа. ЖДҮ эрхлэгчид хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна гэжээ.

Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр зах зээлийн орчны ерөнхий индексийг **(-0.11)** буюу муугаас илүүтэйгээр боломжийн байна гэсэн дүгнэлтийг ЖДҮ эрхлэгчид өглөө /Зураг 4.4/. 2011-2012 онуудын судалгааны дүнгээс харахад зах зээлийн орчны ерөнхий индексийг тодорхойлогч үзүүлэлтүүдээр нь задлан авч үзвэл ЖДҮ эрхлэгчид зах зээлд шударга өрсөлдөөн хангалттай сайн явагдахгүй байгаа⁸ нь зах зээлийн орчны гол хүндрэл болж байна гэж үзэж байсан байна.

Зураг 4.4 Зах зээлийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зах зээлийн орчныг илэрхийлэх хүчин зүйлсээс **хэрэглэгчдийн худалдан авах чадвар (-0.39)** хамгийн муу үнэлгээтэй гарлаа. ЖДҮ эрхлэгчид хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна гэжээ. Түүнчлэн зах зээлийн багтаамж муу, зах зээлд шударга өрсөлдөөн төдийлөн сайн биш гэж үзсэн нь судалгааны үр дүнгээс харагдлаа /Зураг 4.5/

⁸ Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2011-2012).

Зураг 4.5 Зах зээлийн орчин, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Шигтгээ 4.1. Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан (2013)

Өрсөлдөх чадварын индекс нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл бөгөөд Монгол Улсын өрсөлдөх чадварыг ижил төстэй улс орнуудтай харьцуулах боломж олгохын зэрэгцээ тухайн улсын өрсөлдөх чадварын өсөлт, бууралт, тогтмол байдлын талаарх мэдээллийг өгдөг. Мөн зэрэглэлд хамрагдсан улс өрсөлдөх чадварын зэрэглэлийг тодорхойлох, өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг сайжруулах, шинэчлэх боломжийг олгодог. Дэлхийн өрсөлдөх чадварын индекс нь өрсөлдөх чадварыг тодорхойлох 12 тулгуур үзүүлэлтэд үндэслэн тооцдог.

Монгол улсын өрсөлдөх чадварын зэрэглэл



Эх үүсвэр: The Global Competitiveness Report (2013)

Монгол улс уг судалгаанд 2005 оноос эхлэн хамрагдсан бөгөөд 2013-2014 оны тайлан судалгаагаар 3.7 оноогоор 148 орноос 107-р байрт орсон нь өнгөрсөн онд 144 орноос 93-р байрт орсон үзүүлэлтээсээ ухарсан байна. Дээрх графикаас харахад судалгаанд хамрагдсанаас хойшхи хугацаанд Монгол Улсын зэрэглэл 2010-2012 онуудад сайжирч эхний 100-д багтаж байсан бол 2013-2014 оны тайлангаар зэрэглэл нь эрс буурсан байна.

12 тулгуур үзүүлэлтээс ихэнх нь буюу 8 үзүүлэлтийн хувьд Монгол улсын байр ухарсан байна. Манай улсын зэрэглэл ийнхүү эрс буурч нийт 148 орноос эхний 100-д багтаж чадахгүй болоход гуравдугаар тулгуур үзүүлэлт болох макро эдийн засгийн тогтвортой байдлын оноо 3.7 болж, уг үзүүлэлт өмнөх тайлангийн зэрэглэлээс 78 байраар ухарч, 130 дугаар байранд орсон нь ихээхэн нөлөөлсөн байна. Мөн хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдал, бараа бүтээгдэхүүний

зах зээлийн үр ашигтай байдал гэсэн үзүүлэлтүүд тус бүр 10 гаруй байраар ухарсан нь гол нөлөөлсөн байна.

Монгол улсын өрсөлдөх чадварын зэрэглэл 2012-2013




Эх үүсвэр: The Global Competitiveness Report (2012,2013)

Аймаг, нийслэлээр

Зах зээлийн орчны ерөнхий индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Булган, Говь-Алтай, Завхан, Ховд, Сэлэнгэ аймгийн санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид бизнес эрхлэх зах зээлийн орчин хангалттай сайн бүрдээгүй гэж үзжээ /Зураг 4.6/.

Зураг 4.6 Зах зээлийн орчин, аймгуудаар

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Харин Баян-Өлгий, Дархан-Уул, Говьсүмбэр аймгууд болон Улаанбаатар хотод бизнес эрхлэгчид бусад аймгуудтай харьцуулахад зах зээлийн орчин харьцангуй боломжийн байгаа гэсэн үнэлгээг өгчээ.

Зах зээлийн орчинг тодорхойлогч үзүүлэлтүүдийн хувьд задлан авч үзвэл Архангай, Говь-Алтай, Ховд болон Завхан аймгийн түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад

хэрэглэгчдийн худалдан авах чадварт муу гэсэн үнэлгээг өгсөн байна /Хүснэгт 4.2/.

Хүснэгт 4.2 Зах зээлийн орчин, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/

	Зах зээлийн багтаамж	Зах зээлийн өрсөлдөөн	Мэдээллийн хүртээмж	Технологийн дэвшил	Хэрэглэгчдийн худалдан авах чадвар
Улсын дүн	-0.31	-0.07	0.05	0.15	-0.39
Архангай	-0.35	-0.18	0.18	0.23	-1.13
Баян-Өлгий	-0.23	0.04	0.20	0.25	-0.43
Булган	-0.67	-0.42	-0.30	-0.26	-0.70
Баянхонгор	-0.35	0.15	0.15	0.12	-0.47
Дархан-Уул	-0.21	0.33	0.16	0.32	-0.51
Дорнод	-0.31	0.06	0.06	0.14	-0.62
Дорноговь	-0.30	0.07	0.13	0.03	-0.27
Дундговь	-0.43	0.07	0.21	0.32	-0.63
Говь-Алтай	-0.63	-0.17	-0.23	-0.07	-1.10
Говьсүмбэр	-0.15	0.20	0.10	0.10	0.10
Хэнтий	-0.41	-0.28	0.03	-0.14	-0.62
Ховд	-0.46	-0.33	-0.11	-0.11	-1.02
Хөвсгөл	-0.25	0.00	0.03	0.23	-0.79
Орхон	-0.44	-0.17	-0.04	0.12	-0.72
Сэлэнгэ	-0.53	-0.39	-0.10	-0.06	-0.78
Сүхбаатар	-0.57	-0.23	0.13	0.30	-0.03
Төв	-0.21	0.15	0.00	0.10	-0.32
Улаанбаатар	-0.22	-0.05	0.09	0.22	-0.17
Өмнөговь	-0.52	-0.02	-0.02	0.12	-0.68
Увс	-0.43	-0.11	-0.04	0.07	-0.67
Өвөрхангай	-0.40	-0.41	-0.24	-0.10	-0.67
Завхан	-0.75	-0.33	-0.06	-0.20	-0.80

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Булган, Өмнөговь болон Завхан аймгийн ЖДҮ эрхлэгчид өөрийн аймагт бүтээгдэхүүний борлуулах зах зээлийн багтаамж муу гэж үзжээ. Харин Говьсүмбэр, Төв, Дархан-Уул аймгуудад болон нийслэлд үйл ажиллагаа эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад уг үзүүлэлтийг боломжийн гэж дүгнэлээ.

Булган, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн ЖДҮ эрхлэгчид мэдээллийн хүртээмжийг хангалттай сайн биш гэж дүгнэсэн бол бусад аймгууд болон нийслэлд бизнес эрхлэгчид харьцангуй боломжийн гэж үзлээ.

2011-2014 онуудын хоорондох зах зээлийн ерөнхий орчны индексийг улс, Улаанбаатар, аймгуудын дунджаар харьцуулан харвал түүвэр судалгаа явуулсан хугацаанд аймгуудын дундаж нь улс болон Улаанбаатарын дүнгээс харьцангуй муу гарсан байна /Хүснэгт 4.3/.

Хүснэгт 4.3 Зах зээлийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/

	2011	2012	2014
Улс	-0.37	-0.28	-0.11
Улаанбаатар	-0.34	-0.21	-0.02
Аймгуудын дундаж	-0.42	-0.36	-0.21

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Улс, Улаанбаатар, аймгуудын зах зээлийн ерөнхий орчны индекс энэ удаагийн судалгааны дүнгээр 2011 болон 2012 судалгаатай харьцуулахад сайжирсан дүнгэй байна.

Дүгнэлт

ЖДҮ эрхлэгчид хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд зах зээлийн орчныг муугаас илүүтэйгээр боломжийн байна гэж үзсэн байна.

Зах зээлийн орчныг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Булган, Говь-Алтай, Завхан, Ховд, Сэлэнгэ аймгийн санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид бизнес эрхлэх зах зээлийн орчин хангалттай сайн бүрдээгүй гэжээ.

Зах зээлийн орчинг тодорхойлогч үзүүлэлтүүдийн хувьд задлан авч үзвэл Архангай, Говь-Алтай, Ховд болон Завхан аймгийн түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид бусад аймагтай харьцуулахад хэрэглэгчдийн худалдан авах чадварт муу гэсэн үнэлгээг өгсөн байна.

Улс, Улаанбаатар, аймгуудын зах зээлийн орчин энэ удаагийн судалгааны дүнгээр 2011 болон 2012 судалгаатай харьцуулахад сайжирсан дүнтэй байна.

4.3 Зардлын байдал


ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулахад гарах зардлын өнөөгийн байдлыг тогтоож, аль зардал ЖДҮ эрхлэгчдэд хүндрэл учруулж байгааг тандах зорилго тавьсан болно.

Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр зардлын байдлын ерөнхий индексийг (-0.63) буюу хүндрэлтэй гэсэн дүгнэлтийг ЖДҮ эрхлэгчид өглөө /Зураг 4.7/. 2011-2012 онуудын судалгааны дүнтэй харьцуулахад зардлын байдлын ерөнхий индекс буурсан хандлагатай боловч ЖДҮ эрхлэгчдэд хүндрэлтэй хэвээр байна.

Зураг 4.7 Зардлын байдал

/+2= Их хүндрэлтэй, -1= Хүндрэлтэй, 0= Хүндрэлтгүй/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Зардлын байдлын ерөнхий индексийг тодорхойлогч үзүүлэлтүүдээр нь задлан авч үзвэл ЖДҮ эрхлэгчид зээлийн хүүний болон түүхий эдийн зардал хамгийн их хүндрэл үзүүлж байна гэж хариулжээ.

Харин захиргаа үйл ажиллагаа, харилцаа холбоо, судалгаа шинжилгээ, зар сурталчилгааны зардал бизнес эрхлэхэд төдийлөн хүндрэл үзүүлдэггүй гэжээ /Зураг 4.8/.

ЖДҮ эрхлэгчдэд зээлийн хүүний зардал хамгийн их хүндрэл болж байна гэж үзсэн нь санхүүжилтийн орчны зээлийн хүү өндөр байна гэсэн үр дүнтэй нийцтэй гарсан байна.


Мөн түүхий эдийн зардал гол хүндрэлүүдийн нэг гэж судалгаанд оролцогчид үзжээ. Энэхүү үзүүлэлтийг 2012 онтой харьцуулахад буурсан дүнтэй байна⁹. Үүнд Монголбанкнаас инфляцийг бууруулж нам дор түвшинд тогтвортой барих зорилтын хүрээнд Засгийн Газартай хамтарч өргөн хэрэглээний гол бараа бүтээгдэхүүн болон барилгын голлох материалуудын

⁹ Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2012).

үнийг тогтвортой байлгах талаар шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь нөлөөлжээ.

Зураг 4.8 Зардлын байдал, үзүүлэлтээр

/+2= Их хүндрэлтэй, -1= Хүндрэлтэй, 0= Хүндрэлтгүй/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Шигтгээ 4.2. Зээлийн хүү

Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2013 онд дунджаар 18.5%-тай байсан бөгөөд 2014 оны эхний 5 сарын байдлаар дунджаар 19.1% хүрсэн. Харин Үнэ тогтворжуулах хөтөлбөрт олгосон зээлийн оруулж тооцвол зээлийн жигнэсэн дундаж хүү 2013 оны эцэст 14.9%-тай байсан бол 2014 оны 5 дугаар сарын байдлаар 17.2%-тай байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү




Эх үүсвэр: Монголбанк

Аймаг, нийслэлээр

Зардлын байдлын ерөнхий индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Ховд, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн ЖДҮ эрхлэгчид бусад аймгуудтай харьцуулахад зардлын байдал их хүндрэлтэй байна гэж үзжээ. Харин Төв, Дорноговь, Говьсүмбэр аймгийн ЖДҮ эрхлэгчдийн зардлын байдалд өгсөн үнэлгээ нь бага байна /Зураг 4.9/.

Зураг 4.9 Зардлын байдал, аймгуудаар

/-2= Их хүндрэлтэй, -1= Хүндрэлтэй, 0= Хүндрэлтгүй/




Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Зардлын байдлыг тодорхойлогч үзүүлэлтүүдийг аймаг, нийслэл хотын хэмжээнд задлан авч үзвэл Өвөрхангай, Ховд, Архангай, Сүхбаатар, Хөвсгөл аймагт бизнес эрхлэгчид зээлийн хүүний зардлыг бусад аймагтай харьцуулахад хамгийн их хүндрэл үзүүлж байна гэж үзжээ. Харин Говьсүмбэр, Өмнөговь болон Дорноговь аймагт ЖДҮ эрхлэгчид хүүний зардал харьцангуй бага хүндрэлтэй гэж дүгнэлээ.

Шигтгээ 4.3. Түрээсийн зардал

Орон сууц түрээслэх үнэ



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

Дээрх графикт 2011-2014 оны хоорондох орон сууц түрээсийн үнийг харуулсан бөгөөд нэг өрөө байр түрээслэх үнэ 2013 оны 6 дугаар сараас огцом өссөн дүнтэй байгаа нь 6 дугаар сард орон сууц ипотекийн санхүүжилтийг хэрэгжүүлж эхэлсэнтэй хамааралтай байх талтай.

2011-2014 онуудын хоорондох зардлын байдлын ерөнхий орчны индексийг улс, Улаанбаатар, аймгуудын дунджаар харьцуулан харвал түүвэр судалгаа явуулсан хугацаанд Улаанбаатар хотынх нь улс болон аймгуудын дунджаас муу гарсан байна /Хүснэгт 4.4/.

Хүснэгт 4.4 Зардлын байдал

/-2= Их хүндрэлтэй, -1= Хүндрэлтэй, 0= Хүндрэлтгүй/

	2011	2012	2014
Улс	-0.90	-0.94	-0.63
Улаанбаатар	-0.94	-0.96	-0.64
Аймгуудын дундаж	-0.87	-0.94	-0.62

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн

Улс, Улаанбаатар, аймгуудын зардлын байдлын ерөнхий орчны индекс энэ удаагийн судалгааны дүнгээр 2011 болон 2012 судалгаатай харьцуулахад сайжирсан дүнтэй байна.

Дүгнэлт

ЖДҮ эрхлэгчдэд зээлийн хүүний болон түүхий эдийн зардал хамгийн их хүндрэл учруулж байгаа бөгөөд түүвэр судалгааны үр дүнгээр зардлын байдалд хүндрэлтэй гэсэн үнэлгээг өглөө. 2011-2012 онуудын судалгааны дүнтэй харьцуулахад зардлын байдлын ерөнхий индекс буурсан хандлагатай боловч ЖДҮ эрхлэгчдэд хүндрэлтэй хэвээр байна.

ЖДҮ эрхлэгчдэд зээлийн хүүний зардал хамгийн их хүндрэл болж байна гэж үзсэн нь санхүүжилтийн орчны зээлийн хүү өндөр байна гэсэн үр дүнтэй нийцтэй гарсан байна.

Мөн түүхий эдийн зардал гол хүндрэлүүдийн нэг гэж судалгаанд оролцогчид үзжээ. Энэхүү үзүүлэлтийг 2012 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад буурсан байна. Үүнд Монголбанк, Засгийн газрын хамтран хэрэгжүүлж буй өргөн хэрэглээний гол бараа бүтээгдэхүүн болон барилгын голлох материалуудын үнийг тогтвортой байлгах талаар шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь нөлөөлсөн байх талтай.

Хүснэгт 4.5 Зардлын байдал, үзүүлэлтээр

(/2= Их хүдрэлтэй, -1= Хүдрэлтэй, 0= Хүдрэлтгүй)

	Түрээсийн зардал	Түүхий эдийн зардал	Тоног төхөөрөмжийн зардал	Цалингийн зардал	Дулаан усны зардал	Эрчим хүч, цахилгааны зардал	Тээврийн зардал	Захиргаа, үйл ажиллагааны зардал	Харилцаа холбооны зардал	Зар сурталчилгааны зардал	Зээлийн хүүний зардал	Шимтгэл, хураамжийн төлбөр	Судалгаа, шинжилгээний зардал
Улсын дүн	-0.79	-0.82	-0.76	-0.67	-0.57	-0.57	-0.67	-0.48	-0.37	-0.46	-0.85	-0.77	-0.46
Архангай	-0.43	-0.85	-0.68	-0.525	-0.58	-0.58	-0.88	-0.23	-0.15	-0.18	-1.25	-0.95	-0.25
Баян-Өлгий	-0.65	-0.82	-0.88	-0.79	-0.56	-0.57	-0.67	-0.47	-0.30	-0.36	-1.11	-1.04	-0.66
Булган	-0.93	-0.86	-0.89	-0.63	-0.64	-0.52	-0.76	-0.68	-0.30	-0.29	-1.08	-0.79	-0.58
Баянхонгор	-0.82	-0.91	-0.88	-0.82	-0.65	-0.50	-0.76	-0.48	-0.26	-0.33	-1.06	-1.12	-0.45
Дархан-Уул	-0.47	-0.81	-0.86	-0.58	-0.48	-0.47	-0.44	-0.41	-0.28	-0.41	-1.03	-0.97	-0.72
Дорнод	-0.50	-0.72	-0.56	-0.51	-0.62	-0.54	-0.76	-0.31	-0.14	-0.22	-0.81	-0.79	-0.30
Дорноговь	-0.70	-0.63	-0.48	-0.33	-0.57	-0.30	-0.37	-0.24	-0.10	-0.10	-0.97	-0.67	-0.33
Дундговь	-0.27	-0.76	-0.83	-0.75	-0.66	-0.69	-0.50	-0.32	-0.21	-0.15	-0.83	-0.80	-0.29
Говь-Алтай	-0.39	-1.17	-0.93	-0.63	-0.63	-0.87	-0.77	-0.50	-0.27	-0.66	-0.97	-0.93	-0.53
Говьсүмбэр	-0.15	-0.35	-0.20	-0.20	-0.25	-0.25	-0.15	-0.10	-0.10	-0.10	-0.60	-0.50	-0.35
Хэнтий	-0.58	-0.89	-0.90	-0.89	-0.59	-0.55	-0.76	-0.48	-0.26	-0.34	-1.03	-0.79	-0.67
Ховд	-0.93	-0.94	-0.98	-0.64	-0.65	-0.52	-0.89	-0.55	-0.31	-0.50	-1.36	-1.23	-0.82
Хөвсгөл	-0.44	-0.72	-0.65	-0.93	-0.49	-0.48	-0.70	-0.35	-0.10	-0.13	-1.33	-1.30	-0.41
Орхон	-0.75	-0.88	-0.90	-0.65	-0.62	-0.60	-0.69	-0.48	-0.39	-0.50	-0.94	-0.87	-0.65
Сэлэнгэ	-0.62	-0.81	-0.79	-0.71	-0.72	-0.77	-0.81	-0.70	-0.47	-0.61	-1.02	-0.89	-0.74
Сүхбаатар	-0.60	-0.90	-0.73	-0.60	-1.07	-1.13	-0.77	-0.40	-0.30	-0.33	-1.27	-1.20	-0.47
Төв	-0.67	-0.85	-0.70	-0.41	-0.44	-0.51	-0.51	-0.41	-0.18	-0.27	-0.63	-0.67	-0.24
Улаанбаатар	-0.97	-0.78	-0.73	-0.70	-0.55	-0.55	-0.64	-0.53	-0.47	-0.58	-0.70	-0.66	-0.44
Өмнөговь	-0.38	-1.18	-0.78	-0.78	-0.32	-0.56	-0.84	-0.06	-0.08	-0.06	-1.06	-0.54	-0.06
Увс	-0.62	-0.95	-0.88	-0.65	-0.54	-0.41	-0.68	-0.39	-0.29	-0.31	-1.07	-0.86	-0.58
Өвөрхангай	-0.58	-0.91	-0.81	-0.90	-0.86	-0.86	-0.88	-0.54	-0.49	-0.68	-1.35	-0.88	-0.51
Завхан	-0.40	-0.86	-0.96	-0.66	-0.55	-0.64	-0.98	-0.39	-0.29	-0.14	-0.80	-0.90	-0.37

Эх үүсвэр: Монголбанк, ЖДУ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

САНХҮҮЖИЛТИЙН ОРЧИН



Санхүүжилтийн эх үүсвэр: ЖДҮ эрхлэгчдийн хувьд Олон улсын байгууллага болон Засгийн газрын хөнгөлттэй зээлд хамрагдах боломж болон хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах боломж муу гэж 45 орчим хувь нь хариулсан байна. Харин банкны санхүүлтэнд хамрагдах боломж болон өөрийн хөрөнгийн хүрэлцээ харьцангуй боломжийн гэж үзжээ.

Зээлийн нөхцөл: Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 58 орчим хувь нь зээлийн хүү өндөр байна гэж үзжээ. Харин хугцаа болон хэмжээний хувьд боломжийн гэсэн хариултыг өгсөн байна.


Бусад : Нийт судалгаанд оролцогчдын 52% нь зээлийн батлан даалтанд хамрагдах боломж бага гэж үзсэн байна. Мөн барьцаа хөрөнгийн үнэлгээ муу гэж 51% нь үзсэн бөгөөд зээл олгох үйл ажиллагаа харьцангуй боломжийн гэсэн хариултуудыг өгчээ.

БҮЛГИЙН АГУУЛГА:

- ОУБ, ЗГ-ын хөнгөлттэй зээлийн олдоц
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээ
- Хөрөнгийн захаас санхүүжилт авах боломж
- Банкны санхүүжилтэнд хамрагдах боломж
- ББСБ-ын санхүүжилтэнд хамрагдах боломж
- Зээлийн хүү, хугацаа, хэмжээ
- Зээлийн батлан даалтын санд хамрагдах боломж
- Барьцаа хөрөнгийн үнэлгээ
- Зээл олгох үйл явц

Төрөөс ЖДҮ-ийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийн дэмжих талаар авах арга хэмжээний хүрээнд 2007 оны 7 дугаар сарын 27-ны өдөр “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийг батлан гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Хуулийн 5 дугаар бүлгийн 15.1.4-т жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн талаар дэмжих, тэдгээрийн өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах талаар тусгажээ. ЖДҮ эрхлэгчдийг Төрийн зүгээс дэмжиж, холбогдох хууль эрх зүйн орчныг бүрдүүлсний үр дүнд ЖДҮ эрхлэгчид Төсөв-тусгай сан, Гадаад эх үүсвэр (ОУБ), Арилжааны банкны зээл зэрэг голлох 3 эх үүсвэрээс санхүүжиж байна.

Зураг 5.1 ЖДҮ эрхлэгчидэд олгосон зээл



Эх үүсвэр: Монголбанк

Банкны салбарын хэмжээгээр 2014 оны I улирлын байдлаар зээлийн өрийн үлдэгдэл 10.1 их наяд төгрөгт хүрээд байна. Үүний 17% буюу 1.8 их наяд төгрөгийг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд болон ААН-д олгожээ. Уг зээлийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг 48.4 мянган иргэн болон 4.5 мянган ААН-д олгосон байна.


Нэгдсэн дүн

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн харилтаар санхүүжилтийн орчны ерөнхий индекс өмнөх судалгааны дүнгээс (2012) бага зэрэг сайжирч -0.58 болсон бөгөөд 2011 оны түүвэр судалгааны дүнгэй ойролцоо түвшинд гарлаа. Тус үзүүлэлт нь ЖДҮ эрхлэхэд макро эдийн засаг болон нийгмийн байдлын дараа орж буй хүндрэл, бэрхшээл болж байна. Өөрөөр хэлбэл санхүүжилт нь ЖДҮ эрхлэхэд тулгарч буй гол хүндрэлүүдийн нэг хэвээр байгаа бөгөөд энэхүү хандлага нь олон улсын түвшинд хийгдсэн ЖДҮ-ийн талаарх судалгааны үр дүнгүүдтэй нийцтэй гарлаа¹⁰.

¹⁰ ADB-OECD Study on Enhancing Financial Accessibility for SMEs <http://www10.iadb.org/mta/mtalcdi/PE/2014/13909.pdf>

Зураг 5.2 Санхүүжилтийн орчин

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/



Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

ЖДҮ эрхлэгчдийн дунд Улаанбаатар хот болон аймгуудад явуулсан түүвэр судалгааны үр дүнд ОУ-ын байгууллага, ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн олдоц, хөрөнгийн захаас санхүүжилт авах боломж, зээлийн хүү зэрэг нь хамгийн ихээр бэрхшээл болж байгаа үзүүлэлтүүд бөгөөд эдгээр нь өмнөх судалгааны дүнгүүдтэй¹¹ харьцуулахад гол хүндрэл, бэрхшээлүүд хэвээр байна. Зээлийн батлан даалтын санд хамрагдах боломж, барьцаа хөрөнгийн үнэлгээ зэрэг нь удаах хүндрэлүүд болж байгаа бол банкны зээлд хамрагдах боломж, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл олгох үйл ажиллагаа зэрэг хүндрэлүүд харьцангуй бага гэж үзжээ. /Зураг 5.2/.

Зураг 5.3 Санхүүжилтийн орчин, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/



*- ЗБДС- Зээлийн батлан даалтын сан

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Засгийн газраас сүүлийн жилүүдэд дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ЖДҮ эрхлэгчдийг дэмжих чиглэлээр бодлого, хөтөлбөрүүдийг ихээхэн хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд ЖДҮ эрхлэгчдэд зориулан багагүй хэмжээний

¹¹ ЖДҮ-н хөгжил, санхүүжилтийн байдал 2011, 2012 он

хөнгөлөлттэй зээл, хүүний хөнгөлөлт зэрэг үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай санхүүжилтийн дэмжлэгүүдийг үзүүлсээр ирсэн. Тухайлбал:

- 2006 онд Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, үйлдвэрлэгчдийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан”-г байгуулсан.
- Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг орон нутагт хуваарилснаар эрх мэдлийг орон нутагт шилжүүлэх, орон нутагт ЖДҮ-ийг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, зээлийн үр ашгийг дээшлүүлэх зорилготойгоор 2011 онд “Сум хөгжүүлэх сан”-г бий болгосон.
- Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд баглан даалт гаргах зорилгоор 2012 онд “Зээлийн батлан даалтын сан”-г үүсгэн байгуулсан.
- Хөгжлийн банкаас “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр бүхий Жижиг, дунд үйлдвэрлэгчдэд үйлдвэрээ өргөжүүлэхэд нь зориулан хөнгөлөлттэй зээлийг олгох замаар бизнесийг өргөжүүлэх, улмаар ажлын байрыг нэмэгдүүлэхэд, улс орны эдийн засагт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилготой төслийн санхүүжилтийг олгож байна.

Засгийн газрын зүгээс дээрх сангуудаас гадна олон улсын зах дээрээс босгосон “Чингис”, “Самурай” бондын эх үүсвэрээр дотоодын үйлдвэржилтийг хөгжүүлэх, экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох үйлдвэржилтийн төслүүдийг санхүүжүүлэхээр болсон зэрэг тодорхой дэмжлэгүүдийг үзүүлж байгаа явдал юм.

Судалгаанд оролцогчдын зүгээс **ОУ-ын байгууллага болон ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн** олдоц муу буюу хамгийн гол хүндрэл болж байна гэж үзжээ. Үүнд хөнгөлөлттэй зээл олгоход олон шат дамжлагатай мөн орон нутгийн удирдах албан тушаалтны танил талд олгодог, тендер болон төслийн сонгон шалгаруулалт ил, тод бус зэргээс үүдэн зээлд хамрагдах боломж бага байдаг талаар дурьдаж байлаа.

Төрөөс тодорхой хэмжээний ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих зээлийг олгож байгаа боловч хөнгөлөлттэй зээлийн хамрах хүрээ бага, эх үүсвэр хангалттай их биш байгаа нь хөнгөлөлттэй зээлийн олдоц хамгийн муу гэсэн үр дүн гарахад нөлөөллөө. Нөгөө талаас орон нутаг, дүүрэгт хэрэгжилтийн шатандаа алдаа гардаг, зээлийн хэрэгжилт хангалтгүй, зориулалтын

бусаар ашиглах тохиолдлууд гардаг, зээлийн төслөө хангалттай сайн гүйцэтгэдэггүй нь зээл шинээр болон дахин олгохгүй байх гол нөхцөл болдог байна.

Шигтгээ 5.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан:

Анх 1993 онд АНУ-аас Монгол улсад “ХАА-н бүтээгдэхүүний тусламж үзүүлэх тухай” хэлэлцээрийн дагуу тусламжийн шар тос, цөцгийн тосны борлуулалтын орлогоос ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр төвлөрүүлж, Үйлдвэр худалдааны яам /тухайн үеийн нэрээр/-нд жижиг дунд үйлдвэрийг дэмжих санг Жижиг дунд үйлдвэрийн хэлтэс нэртэйгээр байгуулагдсан.

2000 онд Үйлдвэр худалдааны яамны /тухайн үеийн нэрээр/ сайдын тушаалаар Жижиг дунд үйлдвэрийг дэмжих санг өөрийгөө санхүүжүүлж бие даасан хэлбэрээр ажиллуулахаар шинэчлэн зохион байгуулав.

Харин 2006 онд УИХ-аар “Засгийн газрын тусгай сангийн тухай” хуулийн 5.4.6 дэх хэсэг, 14 дүгээр зүйлүүдэд жижиг дунд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-г байгуулсан. Өнөөгийн байдлаар тус сан нь Хөдөлмөрийн яамны харьяа Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Зорилго: Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, үйлдвэрлэгчдийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

Зорилтууд

- ЖДҮ эрхлэгчдэд зориулж урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох;
- Ажлын байр шинээр бий болгосон ажил олгогчдод санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн түрээс /лизинг/-ээр үйлдвэрийн тоног төхөөрөмжийг авч ашиглахад дэмжлэг үзүүлэх;
- Төслийн гүйцэтгэл дээр хяналт тавих;
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор санхүүжилт, дүрэм журмыг бий болгож дотоодын болон гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах;
- ЖДҮ эрхлэгчдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх;
- Зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх;

Хөнгөлөлттэй зээлийн нөхцөл	Орон нутаг	Нийслэл	Бүс нутгийн	Лизинг
Зээлийн хэмжээ	100 сая хүртэл	200 сая хүртэл	200 саяас дээш	100 сая хүртэл
Зээлийн хүү /жил/	7%	7%	7%	10.80%
Зээлийн хугацаа	5 жил	6 жил	7 жил	8 жил
Үндсэн зээлээс чөлөөлөх	Доод хугацаа 1 жил	Доод хугацаа 1 жил	Доод хугацаа 1 жил	Доод хугацаа 1 жил
Төсөл хүлээн авагч	Орон нутгийн хөдөлмөр ийн хэлтэс	Нийслэл, дүүргийн ЗДТҮ-н газар	Хөдөлмөрийн яам ЖДҮХСан	

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2009-2012 оны хооронд олгосон хөнгөлөлттэй зээлд 5171 иргэд, ААН хамрагдсанаас 4113 нь үйл ажиллагаагаа өргөжүүлж үлдсэн 1058 нь шинэ төсөл хэрэгжүүлжээ. Уг хөнгөлөлттэй зээлийн үр дүнд нийт 22825 ажлын байр шинээр бий болсон бол 24477 ажлын байрыг хадгалж үлдсэн байна.

Он	ЖДУ-ийг дэмжих хөрөнгийн эх үүсвэр
2006	1 тэрбум ₮
2007	1 тэрбум ₮
2008	1 тэрбум ₮
2009	30 тэрбум ₮
2010	30 тэрбум ₮
2011	276 тэрбум ₮
2012	50 тэрбум ₮
2013	60 тэрбум ₮

Харин 2013 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр нийт 490 төслийн 59 тэрбум төгрөгийн зээл олгогдож 4330 ажлын байр шинээр бий болж, 1960 ажлын байр хадгалагдсан байна. Олгогдсон нийт хөнгөлөлттэй зээлийн 28 хувийг хөнгөн үйлдвэрлэлийн, 25 хувийг хөдөө аж ахуйн, 14 хувийг хүнсний салбарт олгосон бөгөөд үйлчилгээний салбарт 10 хувийг нь олгожээ.

Сум хөгжүүлэх сан:

Засгийн газар 2011 оноос сумын санг бие даасан байх тал дээр илүү анхааран, орон нутагт эрх мэдлийг шилжүүлэн бий болгож, сумдад жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр байгуулах “Сум хөгжүүлэх сан” бүрдүүлэх, сангийн хөрөнгийг удирдах, төсөл сонгон шалгаруулах, сангаас зээл олгох, эргэн төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах журмыг баталсан.

Уг журмаар сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, шинээр байгуулах, үйл ажиллагааг өргөтгөх, шинээр ажлын байр бий болгох, хадгалахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Зээлийг жилийн 3 хүртэл хувийн хүүтэй, 36 хүртэл сарын хугацаатай олгож, нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээ, хяналтын зардлын хэмжээ, тухайн жилд орон нутагт тэргүүн ээлжинд дэмжих үйлдвэрийн салбар чиглэлийг тус тус тогтоох эрхийг сумын ИТХ-д олгон сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтанд хяналт тавих чиг үүрэг бүхий 7 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус зөвлөл сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчөөр ахлуулан байгуулах, зээлийн төслийн сонгон шалгаруулах зөвлөлийг сумын засаг даргаар ахлуулан зохион байгуулахаар зохицуулсан.

Нэг суманд хүн амын тоо, эдийн засгийн багтаамж, зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлага зэргийг харгалзан 50.0-265.0 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бөгөөд 2013 оны байдлаар нэг суманд 150.0 саяаас 1 тэрбум төгрөг хүртэлх зээлийг олгоод байна.

	330 суманд	Хөнгөлөлттэй зээлийн нохиолууд
Зээлийн хэмжээ	Сумын ИТХ-аар зээлийн дээд хэмжээг тогтооно	Арилжааны банкаар дамжуулахгүй, орон нутаг өөрөө бие дааж шийдвэрлэдэг, сумын засаг дарга шууд гэрээ байгуулан олгодог, Сум хөгжүүлэх сангаас шууд санхүүжүүлдэг, барьцаа, баталгаа нь арилжааны банкных шиг хатуу нөхцөлгүй, зээлийн гэрээг орлогын эх үүсвэрээс хамааруулан хийх боломжтой, эх үүсвэрийг улсын төсөвт буцаан татдаггүй учир тухайн суманд байнгын тасралтгүй эргэх санхүүгийн эх үүсвэр бүрдсэн
Зээлийн хүү /жил/	3% хүртэл	
Зээлийн хугацаа	3 жил	
Төсөл хүлээн авагч	Сумын ЗДТГазарт	

Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр сүүлийн 3 жилд жилийн 24 тэрбум төгрөгийг сумдуудад хуваарилсан байна.

Тэрбум ₮	2011	2012	2013	Нийт
Архангай	1.39	1.39	1.39	4.17
Баян-Өлгий	1.15	1.15	1.15	3.45
Баянхонгор	1.30	1.30	1.30	3.89
Булган	1.12	1.12	1.12	3.35
Говь-Алтай	1.14	1.14	1.14	3.41
Дорноговь	1.14	1.14	1.14	3.42
Дорнод	0.96	0.96	0.96	2.87
Дундговь	1.00	1.00	1.00	3.00
Завхан	1.53	1.53	1.53	4.59
Өвөрхангай	1.61	1.61	1.61	4.82
Өмнөговь	0.99	0.99	0.99	2.96
Сүхбаатар	0.94	0.94	0.94	2.82
Сэлэнгэ	1.45	1.45	1.45	4.34
Төв	1.70	1.70	1.70	5.10
Увс	1.23	1.23	1.23	3.69
Ховд	1.23	1.23	1.23	3.68
Хөвсгөл	1.62	1.62	1.62	4.86
Хэнтий	1.34	1.34	1.34	4.02
Дархан-Уул	0.51	0.51	0.51	1.53
Орхон	0.33	0.33	0.33	0.98
Говь-Сүмбэр	0.37	0.37	0.37	1.10
Нийт	24.00	24.00	24.00	72.00

ЖДУ эрхлэгч Сум хөгжүүлэх сангийн төсөд хамрагдах явц:

- Засаг даргын тамгын газарт төслөө өгөх
- ЖДУ эрхлэгч, иргэдийн төлөөлөөс бүрдсэн сум хөгжүүлэх сангийн зөвлөлөөр хэлэлцэн шийдвэр гаргана
- Сумын Засаг дарга дэмжигдсэн төслийг хэрэгжүүлэгч ЖДУ эрхлэгчтэй гэрээ байгуулна
- Зээлдэгчдэд зээл олгогдоно.

Эх үүсвэр: ХЯам, ЖДУ-ийг хөгжүүлэх сан

Мөн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн олодоц муугаас гадна бусад эх үүсвэрүүдээс (тухайлбал хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах боломж) санхүүжилт авах боломж бага байна гэжээ. Азийн зарим орнуудад ЖДУ-үүд хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт авч байгаа бол Манай орны хувьд хөрөнгийн зах зээлийн хөгжил төдийлөн хангалттай бус, иргэд болон ААН-ийн хувьд үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг хомс байдаг нь санал асуулгын үр дүнд нөлөөлсөн байх талтай.

Шигтгээ 5.2 Азийн зарим хөгжиж буй орнууд дахь ЖДУ-ийн санхүүжилт ба Хөрөнгийн зах зээл

Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжүүлж, эрчимжүүлэхэд урт хугацаат санхүүжилт хэрэгтэй байдаг тул Азийн хурдтай эдийн засгийн өсөлт нь уламжлалт эх үүсвэр болох банкны зээлээс гадна бусад урт хугацаат санхүүжилтийн загварын хөгжлийг шаардах болсон. Хөрөнгийн зах зээл (хувьцаа болон корпорацийн бонд гаргах, гэх мэт) нь Азид эрчимтэй хөгжиж буй жижиг дунд үйлдвэрийн санхүүжилтийг дэмжих олон хувилбаруудын нэг юм. Өнөөгийн байдлаар Азийн хэд хэдэн улс орнууд жижиг дунд үйлдвэрийн санхүүжилтийн эх үүсвэрийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан бий болгох

боломжийг ашиглаж байна.

Бүс	Улс	Биржийн нэр	Б/он	Бүртгэлтэй компаний тоо	Зах зээлийн үнэлгээ сая \$
Зүүн Ази	Хятад	SZSE	2004	701	4534824
		SZSE	2009	355	138371
	Солонгос	KRX	1987	1005	109122000
		KRX	2013		
Өмнөд Ази	Энэтхэг	BSE	2012	22	10091
		NSE	2012	3	
Зүүн өмнөд Ази	Малайз	Bursa. M	2009	112	6935
	Филиппин	PSE	2001	2	586
	Тайланд	SET	1998	81	133017
	Вьетнам	HNX	2009	132	28868424

Эх үүсвэр: Asian SME Finance Monitoring 2013

Тухайлбал Хятадын жижиг дунд үйлдвэрүүд 2004 оноос Шинэний хөрөнгийн биржээр дамжуулан ЖДҮ-ийн санхүүжилтийн эх үүсвэрээ босгох боломж нээгджээ. 2012 оны сүүл гэхэд 1000 гаруй ЖДҮ-үүд хөрөнгийн биржэд бүртгэлтэй болсон ба зах зээлийн үнэлгээ нь 594 тэрбум ам.доллаарт хүрсэн байна. Түүнчлэн хувьцааны санхүүжилтээс гадна банк хоорондын зах болон Хөрөнгийн бирж дээр арилжаалагдах SME Joint Bond, SME Collective Note, SME Private Placement Bond гэсэн гурван төрлийн бондын арга хэрэгслүүдийг бий болгосон.


Малайз болон Тайланд дахь Хөрөнгийн биржүүд нь ЖДҮ-д зориулагдаагүй ч эдгээр нь ЖДҮ-үүд оролцох боломжтой байдаг. Дээрх улсуудаас гадна Солонгос, Энэтхэг, Филиппин, Вьетнам зэрэг орнуудад ЖДҮ-үүд хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт авч байна.

ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүнгээр **зээлийн хүү** (-0.67) бизнес эрхлэхэд нь багаүй хүндрэл учруулж байна гэж үзжээ. Зээлийн жигнэсэн дундаж хүү 2014 оны 2 дугаар улирлын байдлаар 19.7 (*Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зээлийг оруулж тооцвол зээлийн жигнэсэн дундаж хүү 17.3%*) хувьтай байгаа бол орон нутагт олгогдож буй зээлийн хүү улсын дунджаас ойролцоогоор 2 нэгж хувиар илүү байна. Энэ нь нэг талаас хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхлэгчдийн бизнес эрхлэх зардал өндөр, нөгөө талаас хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг банкуудын эх үүсвэрийн зардал өндөр байдагтай холбоотойгоор орон нутаг, улсын дундаж хүүний зөрүү өндөр байна.

Харин ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн жилийн хүү дунджаар 7-10 хувьтай (*сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү жилийн 3%, ЖДҮ хөгжүүлэх сангийн зээлийн хүү жилийн 7-10%, бондын санхүүжилтээр олгож буй зээлийн хүү жилийн 9%*) байгаа боловч уг зээлийн олдоц хангалттай бус байдаг. Ингэснээр ЖДҮ эрхлэгчид банкны бизнесийн зээлд хамрагддаг бөгөөд банкны хүү өндөр байгаа нь үйл ажиллагаа эрхлэхэд хүндрэл учруулж байна гэжээ.

Мөн ЖДҮ эрхлэгчид зээлийн хугацаа богино байгаа явдал нь хүндрэлтэй гэж үзсэн байна. Арилжааны банкууд урт хугацааны эх үүсвэр татаж чаддаггүй нь зээлийн хугацаа богино байхад голлон нөлөөлдөг. Банкууд урт хугацаатай зээл олгох нь тэдгээрийг хөрвөх чадварын эрсдэлд оруулж болзошгүй тул бизнес эрхлэгчдэд урт хугацааны санхүүжилт бага олгоход хүргэж байна. Бизнесийн зээл ихэвчлэн 1-3 хүртэлх жилийн хугацаатай олгогддог бол сүүлийн үед 5 хүртэлх жилийн хугацаатай олгогдож эхэлсэн байна.

Зураг 5.4 Зээлийн хүү



Эх үүсвэр: Монголбанк

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид тулгарч буй дээрх гол хүндрэлүүдээс гадна зээлийн батлан даалтын санд хамрагдах боломж, зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээ, ББСБ-ын зээлд хамрагдах боломж, зээлийн хугацаа, хэмжээ зэрэг нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд ерөнхийдөө хүндрэлтэй гэж үзэж байна.

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл олгох үйл ажиллагаа болон банкны зээлийн олдоц зэрэг үзүүлэлтүүдийг харьцангуй боломжийн гэж дүгнэсэн байна.

Хүснэгт 5.1 Санхүүжилтийн орчин, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/ , аймаг болон нийслэл хот

	Өөрөөн хөрөнгийн хүрэлцээ	Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн олоц	ОУ-ын байгууллагын хөнгөлөлттэй зээлийн олоц	Банкны санхүүжилтэнд хамрагдах боломж	ББСБ-ын санхүүжилтэнд хамрагдах боломж	Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авах боломж	Зээлийн хүү	Зээлийн хугацаа	Зээлийн хэмжээ	Зээлийн батлан даалтын санд хамрагдах боломж	Зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээ	Зээл олгох үйл ажиллагаа, явц
Улсын дүн	-0.33	-0.89	-0.98	-0.38	-0.53	-0.76	-0.67	-0.51	-0.49	-0.57	-0.56	-0.32
Архангай	-0.05	-1.48	-1.68	-0.15	-0.64	-1.18	-1.23	-0.78	-0.60	-1.00	-0.90	-0.23
Баян-Өлгий	-0.32	-1.02	-1.16	-0.29	-0.63	-1.14	-1.14	-0.63	-0.50	-0.63	-0.60	-0.31
Булган	-0.58	-1.09	-1.23	-0.58	-0.88	-1.09	-0.91	-0.81	-0.91	-0.81	-0.88	-0.60
Баянхонгор	-0.30	-1.12	-1.41	-0.09	-0.52	-1.19	-0.79	-0.48	-0.33	-0.70	-0.64	-0.09
Дархан-Уул	-0.56	-1.14	-1.32	-0.19	-0.30	-0.96	-0.88	-0.56	-0.38	-0.63	-0.46	-0.22
Дорнод	-0.26	-1.00	-1.25	-0.24	-0.43	-1.21	-0.94	-0.75	-0.43	-0.72	-0.80	-0.17
Дорноговь	-0.40	-1.10	-1.33	-0.43	-0.83	-0.97	-1.00	-0.60	-0.70	-0.90	-0.80	-0.50
Дундговь	-0.41	-1.14	-1.30	-0.25	-0.75	-1.11	-1.17	-0.77	-0.79	-0.78	-0.93	-0.31
Говь-Алтай	-0.50	-1.43	-1.67	-0.07	-1.10	-1.37	-1.20	-0.50	-0.60	-0.97	-1.07	-0.30
Говьсүмбэр	-0.05	-1.05	-1.10	0.15	-0.70	-1.00	-0.35	-0.55	-0.50	-0.35	-0.60	-0.10
Хэнтий	-0.50	-1.03	-1.41	-0.14	-0.39	-1.00	-0.68	-0.50	-0.36	-0.45	-0.36	-0.03
Ховд	-0.47	-1.22	-1.20	-0.56	-1.27	-1.32	-1.26	-1.04	-0.98	-1.18	-0.98	-0.56
Хөвсгөл	-0.28	-1.40	-1.55	-0.87	-1.05	-1.32	-1.28	-1.10	-1.08	-1.26	-0.75	-0.55
Орхон	-0.40	-1.04	-1.20	-0.49	-0.63	-1.06	-0.96	-0.68	-0.53	-0.62	-0.49	-0.33
Сэлэнгэ	-0.34	-1.08	-1.15	-0.37	-0.75	-0.98	-1.08	-0.72	-0.68	-0.77	-0.67	-0.43
Сүхбаатар	-0.23	-1.30	-1.53	-0.23	-1.00	-1.70	-1.10	-0.67	-0.47	-0.80	-0.90	-0.23
Төв	-0.45	-0.82	-0.82	-0.46	-0.48	-0.70	-0.66	-0.55	-0.62	-0.68	-0.60	-0.48
Улаанбаатар	-0.27	-0.68	-0.71	-0.43	-0.40	-0.46	-0.41	-0.36	-0.37	-0.40	-0.43	-0.31
Өмнөговь	-0.56	-0.96	-1.33	-0.24	-0.46	-1.16	-0.84	-0.62	-0.56	-0.51	-1.02	-0.56
Увс	-0.39	-1.04	-1.23	-0.41	-0.87	-1.07	-0.80	-0.67	-0.72	-0.75	-0.56	-0.15
Өвөрхангай	-0.51	-1.42	-1.63	-0.28	-0.64	-1.35	-1.12	-0.79	-0.79	-0.55	-0.63	-0.35
Завхан	-0.25	-0.98	-1.24	-0.15	-0.55	-1.13	-0.61	-0.38	-0.35	-0.76	-0.47	-0.06

Эх үүсвэр: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгааны үр дүн (2014)

Аймаг, нийслэлээр


Санхүүжилтийн орчны ерөнхий индексийг аймаг, нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Хөвсгөл, Ховд, Говь-Алтай, Булган, Сүхбаатар, Өвөрхангай аймгуудаас санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид улсын дундажтай харьцуулахад санхүүжилтийн орчин хамгийн хүндрэлтэй гэж үнэлжээ. Харин Завхан, Хэнтий, Говьсүмбэр зэрэг аймгууд санхүүжилтийн орчинг харьцангуй боломжийн гэж дүгнэсэн байна /Зураг 5.5/.

Санхүүжилтийн орчинд хамгийн тааруу үнэлгээ өгсөн Хөвсгөл, Ховд аймгуудын ЖДҮ эрхлэгчид хөнгөлөлттэй зээлийн олоц, хөрөнгийн захаас санхүүжилт авах боломж, зээлийн хүү болон зээлийн батлан даалтыг хамгийн хүндрэлтэй гэсэн ба Говь-Алтай, Булган, Сүхбаатар аймгуудын ЖДҮ эрхлэгчид мөн эдгээр хүндрэлүүдийг дурджээ /Хүснэгт 5.1/. ЗГ, ОУБ-ын хөнгөлөлттэй зээлийн олоц муу гэж ихэнх аймгууд үзсэн нь орон нутаг дахь ЖДҮ эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн олоц төдийлөн сайн биш байгааг харуулж байна.

Харин санхүүжилтийн орчинд улсын дундаж болон бусад аймгуудаас хамгийн сайн үнэлгээг өгсөн

Зураг 5.5 Санхүүжилтийн орчин, аймгуудаар

/-2=маш муу, -1= муу, 0=боломжийн, 1= сайн, 2=маш сайн/



Хэнтий, Говьсүмбэр аймгуудын судалгаанд хамрагдагсад хөнгөлөлттэй зээлийн олдцоос бусад үзүүлэлтүүдэд ерөнхийдөө боломжийн гэж үзсэн. Ялангуяа банкны санхүүжилт, зээл олгох үйл ажиллагаад аймгууд бусдаас сайн үнэлгээг өгчээ.

Дүгнэлт

Энэ удаагийн түүвэр судалгаагаар санхүүжилтийн орчинд өгсөн ЖДҮ эрхлэгчдийн үнэлгээ өнгөрсөн судалгааны дүнгээс /2012 он/ бага зэрэг сайжирч эдийн засгийн халалттай үеийн /2011 он/ түвшинтэй ойролцоо гарсан байна. Үүнд Засгийн газраас нийслэл болон орон нутагт ЖДҮ-н хөгжлийг дэмжих тусгай сангуудаар дамжуулан хөнгөлөлттэй зээлийг олгохоос гадна олон улсын зах дээр гаргасан бондын эх үүсвэрүүдээр дотоодын үйлдвэрийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжиж байгаа нь нөлөөлсөн байх талтай. ЖДҮ эрхлэгчид хөнгөлөлттэй зээлээр санхүүжих явдал бага зэрэг нэмэгдсэн ч хамгийн гол хүндрэл хэвээр байгаа буюу хөнгөлөлттэй зээлийн олдоц төдийлөн сайн биш ялангуяа орон нутагт тун муу байна. Үүнд тендер болон төслийн сонгон шалгаруулалт ил, тод бус, хяналт болон хариуцлагын тогтолцоо муу, орон нутгийн удирдах албан тушаалтны танил талд олгодог зэрэг нь нөлөөлж байна.

Түүвэр судалгаанд оролцогчид хөнгөлөлттэй зээлийн олдцоос гадна тулгарч буй гол бэрхшээлүүдийн нэг нь зээлийн хүү гэж үзсэн. Хөнгөлөлттэй зээлийн хүү дунджаар 7-10 хувьтай байгаа боловч түүний олдоц төдийлөн хангалттай биш тул ЖДҮ эрхлэгчид банкнаас бизнесийн зээл авч байна. Гэвч банкны зээлийн хүү өнөөгийн байдлаар дунджаар 19-20 (*хөтөлбөрийг хассан*) хувьтай буюу хөнгөлөлттэй зээлийн хүүнээс 9-13 нэгж хувь өндөр бол орон нутаг дахь банкуудын жигнэсэн дундаж хүү даруй 11-15 нэгжээр өндөр байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчдээс санхүүжилтийн орчинд хамгийн тааруу үнэлгээ өгсөн Хөвсгөл, Ховд аймгуудын хувьд мөн л хөнгөлөлттэй зээлийн олдоц хамгийн хүндрэлтэй байна гэж үзсэн бөгөөд зээлийн хүү хөрөнгийн захаас санхүүжилт авах болон зээлийн батлан даалтанд хамрагдах боломж бага байгаа нь санхүүжилтийн орчинд муугаар нөлөөлдөг гэж үзсэн.

Монголбанк МЕК ХХК-тай хамтран 2014 оны 6 дугаар сард ЖДҮ эрхлэгчдийн дунд “Монгол улс дахь ЖДҮ-ийн хөгжил, түүний санхүүжилт”-ийн талаар санал асуулга явуулж үр дүнг нэгтгэн танилцуулж байна.

Энэхүү судалгаанд нийслэл хотын бүх дүүргүүд болон 21 аймаг хамрагдсан бөгөөд нийт 1850 ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгж (ХК, ХХК, нөхөрлөл, хоршоо), иргэд оролцов. Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн ихэнх нь өмнөх судалгаанд оролцогчдын адил худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, дотоодын хөрөнгө оруулалттай, 1-9 хүртэлх ажилчидтай, 1-10 жил үйл ажиллагаа эрхэлж буй, жилийн 50 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой ААН, иргэд байв.

Бизнес эрхлэхэд (ЖДҮ эрхлэхэд) макро эдийн засгийн байдал, нийгмийн өөрчлөлт, хууль эрх зүйн орчин, дэд бүтцийн хөгжил, санхүүжилтийн эх үүсвэр, зах зээлийн байдал, зардал болон бизнес эрхлэгчдийн өөрсдийн ур чадвар зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг.

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх нь ЖДҮ эрхлэх эдийн засгийн таатай орчин хангалттай бүрдээгүй гэж өмнөх судалгааны адилаар үзсэн нь манай улсад бизнес эрхлэх орчин, боломж төдийлөн бүрдэж чадахгүй байгааг харуулж байна. Хэдийгээр эдийн засгийн өсөлт хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж байгаа ч уг үр шим хүртээмжгүй байгааг судалгаанд оролцогчид илэрхийлж */тэдгээрийн ердөө 17 хувь нь эерэгээр нөлөөлж байна гэж хариулжээ/* байгаагаас харахад нийгэмд бүрэлдэж буй баялаг түүний хуваарилалтын тогтолцоо тэгш бус байгааг гэрчилсээр байна.

Нийгмийн зүгээс ЖДҮ-ийн хөгжилд, ядуурал, ажилгүйдэл хээл хахууль хамгийн гол бэрхшээл байгаа нь өмнөх судалгааны дүнтэй ижил гарчээ. Гэсэн хэдий ч өмнөх судалгаатай харьцуулахад тэдгээрийн үнэлгээ бага зэрэг буурсан байна. Төрийн болон төрийн бус байгууллагын тогтолцоонд эрх бүхий албан хаагчид хээл хахууль авах замаар лиценз, тусгай зөвшөөрөл болон бусад төрлийн холбогдох зөвшөөрлийг олгодог үзэгдэл нийгэмд тодорхой хэмжээгээр байгаа нь¹² бизнес эрхлэгчдэд

¹² Авлигатай тэмцэх газар 2013 онд ирсэн нийт гомдол, мэдээллээс гэмт хэргийн шинжтэй 427 /өмнөх оны үлдэгдэл 5 орсноор/ гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэл журмын дагуу шалгасан бөгөөд нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 103, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 72, боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээний салбарт хамаарах 58, газар, ашигт

нэлээд хүндрэл учруулж байна. Ядуурал, ажилгүйдлийн түвшин өндөр, хэрэглэгчдийн худалдан авах чадварт муу байгаагаас шалтгаалж ЖДҮ эрхлэгчдийн борлуулалт хангалттай түвшинд хийгдэхгүйд хүрч, урт хугацаанд эргэлтийн хөрөнгөөр дутагдах, хэрэв зээлтэй бол зээлийн эргэн төлөлтийн дарамтанд орох зэрэг санхүүгийн хүндрэлүүдтэй тулгарч байгаа талаар судалгаанд оролцогчид онцолж байлаа. Гэмт хэргийн байдалд өгсөн үнэлгээ өмнөх онуудын санал асуулгын дүнгээс нэлээд сайжирсан байна.

Хууль, эрх зүй, зохицуулалтын орчин нь ЖДҮ-ийн хөгжилд хамгийн чухал хүчин зүйлсийн нэг бөгөөд төр, засгаас ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх талаар анхааран ажилласаар байна. “ЖДҮ-ийн тухай хууль”, “ЖДҮ-ийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль”, “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”, “Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” зэрэг хуулийг батлан, мөрдөн ажиллаж байгаа нь ЖДҮ эрхлэгчдэд хууль эрх зүйн орчинд бий болсон томоохон амжилтын илэрхийлэл юм. Энэ удаагийн санал асуулгын дүнгээр хууль эрх зүйн орчны ерөнхий үнэлгээ өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бага зэрэг сайжирсан хэдий ч төдийлөн хангалттай биш байна. Тухайлбал, төрийн байгууллагын үйлчилгээ хууль зүйн орчны үзүүлэлтүүдээс тааруу үзүүлэлттэйд тооцогдож байгаа ч өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад харьцангуй сайжирчээ. Энэ нь төрийн үйлчилгээний цахим ТҮЦ машиныг Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд байршуулсан нь аж ахуй эрхлэгч байгуулага, иргэдэд төрийн зарим үйлчилгээг түргэн шуурхай авах болсон, төрийн байгууллагад гаргасан гомдол саналаа хэрхэн шийдвэрлэж, ямар шатанд явж байгаа талаар онлайнаар мэдэх болсон зэрэгтэй холбоотой юм. Мөн газар эзэмшихтэй холбоотой хууль эрхзүйн орчны үнэлгээ өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад сайжирч, боломжийн гэсэн хариулт нэлээд нэмэгджээ. Судалгаанд оролцогчид өөрсдийн гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн зориулалтаар газраа хувьчилж авч байгаагаас уг үнэлгээ сайжирсан байна. Харин гадаад худалдаа

малтмалын салбарт хамаарах 23, яамдын үйл ажиллагаатай холбоотой 23, УИХ-ын гишүүнд холбогдох 4, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хамааралтай 51, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хамаарах 40, бусад байгууллагад хамаарах 26 гомдол, мэдээлэл байна.

хийх нөхцөлд энэ удаагийн судалгаагаар хамгийн муу үнэлгээг өгсөн байна.

Хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурсан, зах зээлийн багтаамж хангалтгүй байгаа зэрэг нь бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна гэж судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн зарим үзэж байгаа боловч ерөнхийдөө зах зээлийн байдалд өгсөн үнэлгээ өмнөх судалгааны дүнгээс сайжирсан бөгөөд муу гэсэн үнэлгээнээс илүүтэйгээр боломжийн гэж үзжээ.

Бизнес эрхлэхэд чухал хүчин зүйлсийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Судалгааны дүнгээр манай улсын дэд бүтцийн байдал боломжийн гэж дүгнэгдсэн байна. Дэд бүтцийн орчин дотроо зам тээврийн хөгжил хамгийн тааруу үнэлгээг авсан бөгөөд дулаан, усан хангамжийн асуудал үүний дараа орж байгаа боловч боломжийн гэсэн үнэлгээ давамгайлсан байв. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад эдгээрийн үнэлгээ сайжирч, боломжийн үнэлгээ давамгайлах болжээ. Энэ нь 2013 онд Баянхонгор, Дундговь, Дорноговь аймгуудыг хатуу хучилттай замын сүлжээнд холбосон, дулаан усан хангамж сайжирсантай холбоотой. Цахилгаан хангамж болон мэдээлэл холбооны хөгжил харьцангуй сайн үнэлгээг авсан бөгөөд боломжийн үнэлгээ түлхүү байгаа ч сайн гэсэн үнэлгээг зарим судалгаанд оролцогч өгсөн байна. Үүрэн холбоо, интернет хэрэглэгчдийн тоо сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц нэмэгдэж, бүх аймгуудад тэдгээрийн сүлжээ нэвтэрсэн нь мэдээлэл холбооны хөгжил харьцангуй сайн үнэлгээ авах гол шалтгаан болсон хэвээр байна.

Зардлын байдалд ЖДҮ эрхлэгчдээс өгсөн үнэлгээ 2011-2012 онуудын судалгаатай харьцуулахад сайжирсан боловч бизнес эрхлэхэд хүндрэлтэй хэвээр байна. Зээлийн хүү, түүхий эд, түрээс, шимтгэл, хураамжийн зардал хамгийн их хүндрэл учруулсаар байна. Ялангуяа, зээлийн хүүний зардал хамгийн их хүндрэлтэй байгаа бөгөөд үүнийг хэрэглэгчдийн худалдан авах чадвар муудаж, борлуулалтын орлого багассанаас зээлийн төлөлтөнд муугаар нөлөөлж байгаагаар тайлбарлаж байлаа. Мөн түүхий эдийн зардал гол хүндрэлүүдийн нэг гэж судалгаанд оролцогчид үзэж байгаа ч 2012 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад буурсан байна. Үүнд Монголбанк, Засгийн газрын хамтран хэрэгжүүлж буй өргөн хэрэглээний гол бараа бүтээгдэхүүн болон барилгын голлох материалуудын үнийг тогтвортой байлгах талаар шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь нөлөөлсөн байх талтай. Шимтгэл хураамжийн төлбөр хүндрэлтэй гэж үзсэн нь тусгай зөвшөөрөл, лицензийг авах шат дамжлага олон мөн хугацаа их зарцуулагдсан хэвээр байгааг

харуулж байна. Хэдийгээр ЖДҮ эрхлэх зориулалт бүхий тоног төхөөрөмжийг импортын татвараас чөлөөлөх хуулийн хэрэгжилтийг сунгасан ч тоног, төхөөрөмжийн зардал нь хүндрэлтэй хэвээр байгаа нь бизнес эрхлэгчдийн санхүүгийн чадавх муудсаар байгааг илтгэж байна.

Манай улсад ЖДҮ эрхлэхэд хамгийн их бэрхшээл учруулж байгаа хүчин зүйл нь хөгжиж буй улсуудын нэгэн адил санхүүжилтийн асуудал юм. Ялангуяа, барьцаа хөрөнгө, баталгаа байхгүй, зээлийн нөхцөл хатуу /хүү өндөр, хэмжээ бага, хугацаа богино/, хөнгөлөлттэй зээлийн олдоц хомс, хөрөнгийн зах зээлийн хөгжил сул зэрэг нь бизнес эрхлэгчдэд санхүүгийн асуудлаа шийдвэрлэх боломж бүрэлдэхгүйд хүргэж байна.

ЖДҮ эрхлэгчдэд зориулагдсан хөнгөлөлттэй зээлийн олдоцыг сайжруулах нэн тэргүүний шаардлага тулгарч байгаа тул Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг олгоход шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааны тогтолцоог сайжруулах, төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх, хяналтыг сайжруулах, хариуцлагын тогтолцоог бий болгох, ил тод нээлттэй байх чиглэлийг баримталж ажиллах нь зүйтэй юм.

Ерөнхийдөө энэ удаагийн судалгааны үр дүн өмнөх судалгааны дүнгээс сайжирсан байлаа. Ялангуяа, нийгмийн үзүүлэлт, зардлын байдалд өгсөн үнэлгээний индекс 0.3-0.4 нэгжээр сайжирсан байна. Үүний дараагаар дэд бүтэц, зах зээл, хууль, эрх зүйн орчны үнэлгээний индекс 0.1 нэгжээр сайжирчээ. Харин санхүүжилтийн орчинд өгсөн үнэлгээ маш багаар нэмэгдсэн байна.